

## ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ГАДААД БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2009 ОН

### МАЛЫН ХУЛГАЙН ЗӨРЧИЛД ОНОГДУУЛАХ ЗАХИРГААНЫ ШИЙТГЭЛИЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ, ӨӨРЧЛӨХ АРГА, БОЛОМЖ

*Судалгааны код:* СТ-09/207  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* У.Мөнхбат  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ц.Сэвдэнчиг  
*Огноо:* 2009.05.11  
*Сэдвийн агуулга:* Малын хулгайн зөрчилд оногдуулах захиргааны шийтгэлийн хэм хэмжээний эрх зүйн зохицуулалтыг судалж үзсэн. Түүнчлэн уг асуудалтай холбоотой статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн, тухайлбал, Цагдаагийн Ерөнхий Газраас ирүүлсэн статистик, Захиргааны хариуцлагын тухай 36 дугаар зүйлд зааснаар бүртгэгдсэн зөрчлийн судалгаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн статистик мэдээллүүд багтана.

### ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛД

*Судалгааны код:* СТ-09/213  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Судалгааг удирдсан:* Ц.Норовдондог (Ph.D)  
*Гүйцэтгэсэн судлаач:* Б.Буяндэлгэр, Ш.Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батбаяр  
*Огноо:* 2009.04.05  
*Сэдвийн агуулга:* Энэхүү харьцуулсан судалгаанд (1) шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, (2) Гадаадын зарим орны ижил төстэй байгууллагын эрх зүйн зохицуулалт, (3) Шүүхийн ерөнхий зөвлөлийн тулгамдсан асуудал, (4) Шүүхийн ерөнхий зөвлөлийн удирдлага, зохион байгуулалтыг шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байх зарчимд нийцүүлэх зэрэг асуудлуудыг хамруулсан.

### МАНДАТЫН ЭРХ, УИХ-ЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, БАЙЦААН ШИЙТГЭХ ТҮР ХОРОО, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, ХҮНИЙ ЭРХИЙН ОМБУДСМЭН, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ОМБУДСМЭН, ТӨСВИЙН АУДИТ"-ЫН ТУХАЙ

*Судалгааны код:* СТ-09/217  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Мөнхбат, Ш.Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа, К.Пүрэвсүрэн  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ө.Энхтүвшин  
*Огноо:* 2009.11.05  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд (1) Мандат болон УИХ-ын гишүүний бүрэн эрх, нэр томъёо, ойлголт, эрх зүйн зохицуулалт, (2) Байцаан шинжих түр хороо (Турк, Болгар, Унгар), (3) Төсвийн аудит, түүний эрх хэмжээ

(Орос, Турк), (4) Омбудсмэны үндсэн ойлголт, чиг үүрэг, томилох ба түүний эрх зүйн байдал, үйл ажиллагааны хамрах хүрээ, санал гомдол гаргах, түүнийг шалгах, хэрэг үүсгэх. Омбудсмэний бүрэн эрх, үйл ажиллагааны зохион байгуулалт, шийдвэрийг багтаасан болно.

#### **СОНГУУЛИЙН СИСТЕМИЙН ХАРЬЦУУЛАЛТ: ДАВУУ БА СУЛ ТАЛ**

*Судалгааны код:* СТ-09/219  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Базар (Ph.D), А.Пагма (MA)  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Х.Жекей  
*Огноо:* 2009.12.10  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаагаар 1992 оноос явагдсан нийт 5 удаагийн сонгуулийн дүнг нэгтгэн тоймлож үзүүлээ. Эндээс тухайн сонгуульд оролцсон намууд хэдэн хувийн санал авч, Засгийн газраа бүрдүүлж байсныг харах боломжтой юм. Үүний зэрэгцээ нийт 5 удаагийн сонгууль нь сонгуулийн ямар системээр явагдсан болон тэрхүү системийн давуу болон сул талыг харьцуулан үзүүлэв. Мөн өмнөх сонгуулиудын туршлага, үр дүнгээс сонгуулийн системийг өөрчлөх шаардлага урган гарч байгаа гэж үзэж буй өнөөгийн тохиолдолд Монгол Улс сонгуулийн ямар системийг авч хэрэглэх нь сонгогч, нам, эвсэл болоод цаашид парламентын бүтэц хийгээд Засгийн газраа бүрдүүлэхэд давуу талтайг олон улсын экспертүүд санал болгож буйг энэхүү судалгаанд эх сурвалж болгон ашиглав.

#### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-09/222  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ш.Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс  
*Огноо:* 2009.12.25  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаанд УИХ-ын Байнгын болон дэд, түр хороодын талаарх хууль тогтоомжийн харьцуулалт, тухайлбал, Байнгын хорооны үндсэн болон бусад бүрэн эрх, ажлын зохион байгуулалт, Дэд хороо, Түр хорооны талаарх харьцуулалтыг хийсэн. Түүнчлэн, УИХ дахь нам, эвслийн бүлэг, олонх, цөөнхийн асуудлын талаарх зохицуулалт, үүнд, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, УИХ дахь олонх, цөөнхийн эрх зүй, бусад хууль тогтоомжийн харьцуулалтыг хамруулсан.

#### **ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИХ ШААРДЛАГА, БОЛЗОЛЫН ТУХАЙ**

*Судалгааны код:* СТ-09/302  
*Судалгааны төрөл:* Тойм судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ш.Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын Газар  
*Огноо:* 2009.04.05  
*Сэдвийн агуулга:* Судалгааг дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн албан тушаалд тавих шаардлагын хуульд тусгагдсан байдал, зарим санал дүгнэлт,
- Төрийн албан тушаалд тавих болзлын хуульд тусгагдсан байдал, зарим санал дүгнэлт,
- Төрийн албан тушаалд тавих шаардлага, болзол холбогдох хуульд хэрхэн зохицуулагдсан байдал.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТӨРӨӨС ОЛГОДОГ ОДОН, МЕДАЛЬ, ЦОЛНЫ ТАЛААРХИ ТОЙМ СУДАЛГАА**

|                             |   |
|-----------------------------|---|
| <i>Судалгааны код:</i>      | СТ-09/304   |
| <i>Судалгааны төрөл:</i>    | Тойм судалгаа   |
| <i>Гүйцэтгэсэн судлаач:</i> | Ш.Хишигсүрэн  |
| <i>Захиалагч:</i>           | УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу  |
| <i>Огноо:</i>               | 2009.04.17  |
| <i>Сэдвийн агуулга:</i>     | Турк, Англи, Герман зэрэг орны төрөөс олгодог одон, медаль, цолны тухай зарим одон медалийн загварын талаар тоймлон судалсан. Судалгааг төрөөс олгодог одон, медаль, цолны нэр /эх хэлээр/, тухайн шагналыг олгох эрх бүхий субъект, тухайн шагналыг дагалддаг урамшууллын хэмжээ, тухайн шагналыг зохицуулсан эрх зүйн акт, ямар болзол, шалгуурыг харгалзан олгодог гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр, интернетийн хайлтын систем болон тухайн улсын холбогдох цахим хуудсыг ашиглах аргачлалаар гүйцэтгэсэн болно. |

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛД**

|                             |  |
|-----------------------------|--|
| <i>Судалгааны код:</i>      | СТ-09/305  |
| <i>Судалгааны төрөл:</i>    | Тойм судалгаа  |
| <i>Гүйцэтгэсэн судлаач:</i> | Ш.Хишигсүрэн   |
| <i>Захиалагч:</i>           | Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс, Төрийн байгуулалтын байнгын хороо   |
| <i>Огноо:</i>               | 2009.04.11   |
| <i>Сэдвийн агуулга:</i>     | Энэхүү судалгаа нь гурван хэсэгтэй бөгөөд УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн түүхэн тойм гэсэн эхний хэсэгт чуулганы хуралдааны дэгийн 1990 оноос өнөөг хүртэлх эрх зүйн зохицуулалтыг тоймлосон. Дараагийн хэсэг болох Парламентын хуралдааны талаар баримталдаг нийтлэг жишиг хандлагад парламентын хуралдааны дэгийн талаар баримтлах Үндсэн хуулийн зарчим болон бусад зарчмыг тусган, тус зарчмуудыг гадаадын парламент хэрхэн хэрэгжүүлдэг талаар жишээ болон эрдэмтдийн үзэл бодлыг тусгасан болно. Харин сүүлийн УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн хууль тогтоомжийн талаар Үндсэн хуулийн цэцэд гаргасан маргааны тухай гэсэн хэсэгт чуулганы хуралдааны дэгийн хууль тогтоомжийн талаар Үндсэн хуулийн цэцэд гаргасан маргааныг хэрхэн шийдвэрлэснийг хүснэгтээр харуулсан. |

## **АВИЛГА, ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНД СУРТАЛ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АШИГ, СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН АСУУДЛААР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ**

|                          |               |
|--------------------------|---------------|
| <i>Судалгааны код:</i>   | СТ-09/306     |
| <i>Судалгааны төрөл:</i> | Тойм судалгаа |

*Гүйцэтгэсэн судлаач:* У.Мөнхбат, Ш.Хишигсүрэн, К.Пүрэвсүрэн  
*Огноо:* 2009.04.25  
*Сэдвийн агуулга:* Авилга, авилгатай тэмцэх асуудлаар 1990-ээд оноос хойш төрийн бус байгууллага, судлаач, эрдэмтдийн хийсэн нэлээд олон судалгаа байх ба мөн мэдээлэл, лавлагаа, нийтлэлийн хэлбэрээр уг асуудлыг өргөн хүрээнд авч үзсэн байна.  
Авилга, төрийн албаны хүнд суртал, төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчил зэрэг асуудлуудаар бусад судалгааны байгууллагуудын хийсэн судалгаануудыг тоймлон авч үзэв.

## **ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЁС ЗҮЙН АСУУДЛААРХИ ХЭВЛЭЛИЙН НИЙТЛЭЛИЙН КОНТЕНТ-АНАЛИЗИЙН ТҮҮВЭР ХҮСНЭГТ**

*Судалгааны код:* СТ-09/307  
*Судалгааны төрөл:* Тойм судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ю.Эрдэнэтуяа, О.Алтансүх, Б.Ариунжаргал, З.Бауыржан, А.Гомбоцэдэн, Д.Золбоо, Д.Живгаагүнсэл, Б.Мөнхцэцэг, У.Мөнхбат, Т.Мягмаржав, О.Нарантуяа, Ч.Онончимэг, К.Пүрэвсүрэн, Ц.Түвшинзаяа, Б.Цолмонбаяр, Ш.Хишигсүрэн  
*Огноо:* 2009.04.25  
*Сэдвийн агуулга:* Монголын нийгэмд гарсан ардчилсан өөрчлөлтийн үр дүнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх иргэдийн эрх, эрх чөлөө хэрэгжин биелж, хэвлэлийн олон ургалч, ил тод байдал дээшлэн, нийтлэлийн агуулгад тавих албан ёсны хяналт үгүй болсон билээ. Нөгөө талаар Монголын төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах ардчилсан засаглалын тулгуур зарчмыг амьдралд бодитойгоор хэрэгжүүлэхэд хэвлэлийн нийтлэл зохих нөлөө үзүүлсээр байна. Тиймээс энэ судалгаа нь УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх “УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм”-ийн төсөлтэй холбогдуулан сонин хэвлэлд төрийн албан хаагчид, тэр дундаа төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн байдлын талаар юу бичиж нийтэлж байгаад зохих судалгаа хийж бодлогын баримт бичиг боловсруулах, хэлэлцэхэд холбогдох мэдээллийн эх сурвалжийг бүрдүүлэх зорилготой хийсэн юм.

## **ТӨРИЙН БЭЛГЭДЛИЙН АГУУЛГА, АЧ ХОЛБОГДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ**

*Судалгааны код:* СТ-09/310  
*Судалгааны төрөл:* Тойм судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ю.Эрдэнэтуяа, Г.Чулуун  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв  
*Огноо:* 2009.03.03  
*Сэдвийн агуулга:* 2009 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг баталсан УИХ-ын 2009.01.16-ны өдрийн 7 дугаар тогтоолоор Нийтээр тэмдэглэх баярын болон нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг ээлжит чуулганаар хэлэлцэхэд бэлтгэх чиглэлийг УИХ-ын Тамгын газарт өгсөн. Үүнтэй холбогдуулж ТГ-ын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төвөөс доорх нэмэлт танилцуулгыг гаргав.

## **УЛСЫН ИХ ХУРЛЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГЖИЙН ТҮҮХЧИЛСЭН ТАНИЛЦУУЛГА**

*Судалгааны код:* СТ-09/402  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ю.Эрдэнэтуяа  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв  
*Огноо:* 2009.03.03  
*Сэдвийн агуулга:* УИХ-ын судалгаа, шинжилгээний нэгжийн түүхчилсэн танилцуулгыг 1990 онд анх Төрийн бодлого, нийгмийн асуудал судлах төвийг үүсгэн байгуулснаас хойш 2009 онд УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв байгуулагдсан хүртэлх 4 удаагийн өөрчлөлтийг, товч танилцуулгын хамт оруулсан байна.

## **ГАДААДЫН ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ НЭГЖҮҮДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-09/403  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ю.Эрдэнэтуяа, Судалгааны төвийн нийт судлаачид  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв  
*Огноо:* 2009.03.09  
*Сэдвийн агуулга:* Мэдээлэл лавлагаанд Турк, Эстон, Литв, Израиль, Унгар, Грек, Америк, Австрали, Канад, Бельги, Албани, Вьетнам, Тайланд, Энэтхэг, Герман, Финланд, Исланд, Швед, Чех, Солонгос, Бразил, Япон, Украин, Казахстан зэрэг 24 орны парламентын судалгааны нэгжийн харьяалал, статус, товч түүх, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, гаргадаг бүтээгдэхүүн зэргийг хүснэгтээр харьцуулан харуулсан.

## **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД 2005-2009 ОНЫ ХООРОНД ШИНЭЭР БИЙ БОЛГОСОН ОРОН ТОО, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-09/411  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* К.Пүрэвсүрэн  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин  
*Сэдвийн агуулга:* Монгол Улсын 2006-2008 оны төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланд тулгуурлан төрийн албан хаагчдын тоо, цалингийн сангийн өсөлтийн талаар зарим үзүүлэлтийг хүснэгтээр нэгтгэн гаргав. Багцаар гаргасан мэдээллийг Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн газраас авсан мэдээ, материалд тулгуурлан гаргасан болно.

## **ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 28 ДУГААР БҮЛЭГТ ЗОХИЦУУЛСАН ХЭЭЛ ХАХУУЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААРХИ СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-09/414  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* У.Мөнхбат  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн З.Алтай  
*Огноо:* 2009.10.02

*Сэдвийн агуулга:*

Албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын талаар 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн 263-273 дугаар зүйлд тус тус заажээ. Тухайлбал, 268 дугаар зүйлд хээл хахууль авах, 269 дүгээр зүйлд хээл хахууль өгөх, 270 дугаар зүйлд хээл хахууль зуучлах гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлага тусгагдсан байдаг нь энэ төрлийн гэмт хэрэг тухайлбал, авилгын шинжтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн буюу хээл хахууль өгсөн нь, авсан нь ч, мөн зуучилсан нь ч ялгаагүй зохих шийтгэлтэй байх ёстой гэсэн зарчмыг агуулсан байна.

## **УИХ-ЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСГҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-09/416

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлага

*Гүйцэтгэсэн судлаач:* Б.Мөнхцэцэг, Ө.Мөнхтунгалаг, Д.Живгаагүнсэл, Б.Ариунжаргал, Д.Золбоо

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин

*Сэдвийн агуулга:* Судалгаа мэдээллийг хяналт, шалгалтын хэлтсийн жилийн тайланд тусгасан статистик мэдээлэл, Байнгын хороодын тогтоол, хуралдааны тэмдэглэл, ажлын хэсгүүдийн ажлын тайлан болон архивын нэгжүүдийг нэг бүрчлэн түүвэрлэн, хэрэгжилтийн талаарх мэдээллийг олдоцын хэрээр ашиглав. 1996-2009 онуудын УИХ-ын тогтоол, УИХ-ын даргын захирамж, Байнгын хороодын тогтоол, УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалтын хэлтсийн ажлын тайлан, хуралдааны тэмдэглэлүүдээс хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан ажлын хэсгийн тогтоол, үр дүнгийн талаарх материалуудыг шүүн статистик мэдээлэл бэлтгэж нэгтгэн дүгнэв.

## **2010 ОН**

---

### **ТӨРИЙН ОДОН, МЕДАЛЬ, ТҮҮНИЙ ХЭЛБЭР, ОЛГОХ ЖУРМЫН ТАЛААРХИ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-10/201

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Судалгааг удирдсан:* Ц.Норовдондог (Ph.D)

*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Чулуун (MA), А.Пагма (MA), Ш.Хишигсүрэн (LL.M)

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ц.Сэвдэнчиг

*Огноо:* 2010.01

*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгааг Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал, төрийн шагналын өнөөгийн системийг тодорхойлон, бусад орнуудын төрийн шагналын систем, онцлог, түүний дотор пост социалист орнуудын төрийн шагналын системийн шинэчлэлийг харьцуулан манай улсын өнөөгийн төрийн шагналын системийн талаар нэгдсэн дүгнэлт гаргах зорилгын дэвшүүлэн дараах зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хуучин социалист системийн орнуудын төрийн шагналын систем, түүний шинэчлэлийг харьцуулан судлах,
- Монгол төрийн шан харамж, түүний түүхэн уламжлал ба төрийн шагналын өнөөгийн системийг судлах, лавлагаа, мэдээлэл бэлтгэх
- Бусад орнуудын төрийн одон, медалийн систем, түүний онцлогийг харьцуулан судлах
- Төрийн шагналын системийн талаар харьцуулсан дүгнэлт хийх

## **ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН АСУУДЛЫГ БУСАД ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

*Судалгааны код:* СТ-10/203  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Судалгааг удирдсан:* Ю.Эрдэнэтуяа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, Б.Буяндэлгэр, Ю.Эрдэнэтуяа, У.Мөнхбат, Ш.Хишигсүрэн, К.Пүрэвсүрэн, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Энхболд  
*Огноо:* 2010.01.20  
*Сэдвийн агуулга:* Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудлаарх Азийн орнуудын үндсэн хуулийн зохицуулалт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудлаар Европын холбооны зарим улсын үндсэн хуулийн зохицуулалт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудлаар тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын үндсэн хуулийн зохицуулалт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудлаар Араб, Африкийн орнуудын үндсэн хуулийн зохицуулалт, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудлаар Хойд, өмнөд Америкийн орнуудын үндсэн хуулийн зохицуулалт зэргээр харьцуулсан хүснэгтүүдийг гаргасан.

## **УЛС ТӨРИЙН СОНГУУЛИЙН НӨЛӨӨГӨӨР ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ӨӨРЧЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ АСУУДАЛ, ТӨЛӨВ БАЙДАЛ**

*Судалгааны код:* СТ-10/208  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* С.Дорждагва  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батбаяр, З.Энхболд, Ц.Дашдорж  
*Огноо:* 2010.03.31  
*Сэдвийн агуулга:* Улс төрийн сонгуулийн үр дүнд төрийн албан хаагчдын тодорхой хэсэг нь чөлөөлөгдөх болон өөрчлөгддөг жишиг олон улсын практикт байдаг эсэх, Монгол Улсад энэ үйл явц ямар байгаа талаар тодруулах, мөн энэ асуудлыг хуулиар хэрхэн зохицуулдаг эсэх талаар дүгнэлт гаргах, харьцуулан судлах бөгөөд энэ хүрээнд холбогдох кейс, мэдээллийг эрэн хайлт хийсэн боловч уг захиалгад тохирох албан ёсны тоон мэдээлэл олдоогүй тул зарим орны туршлага болон онолын асуудлын хүрээнд судалгааны ажлыг гүйцэтгэв.

## **ТӨРИЙН АЛБАНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД НИЙГМИЙН АУДИТЫН ҮҮРЭГ**

*Судалгааны код:* СТ-10/214  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ө.Энхтүвшин  
*Огноо:* 2010.05.25  
*Сэдвийн агуулга:* Уг харьцуулсан судалгаанд Нийгмийн аудитын тухай ойлголт, зорилго, арга зүй, үндсэн зарчим, Төрийн захиргаан дахь нийгмийн аудитын үйл явц, Нийгмийн аудитын үзүүлэх үр өгөөж, эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлсэн зарим орны туршлагыг судлав.

## **НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ШҮҮМЖ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-10/215  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Р.Хатанбаатар, Ө.Мөнхтунгалаг, Г.Хишигсүрэн, Г.Чулуун  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ө.Энхтүвшин  
*Огноо:* 2010.05.25  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль болон НЭЗБТ хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл заалтын харьцуулалт, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, түүнийг гадаадын зарим орны (Польш, Казахстан, Турк, ОХУ) эрх зүйн зохицуулалт, зарим харьцуулалт болон шинэчилсэн найруулгын төслийн шүүмж, харьцуулалт, дүгнэлт, санал – зөвлөмжийг багтаасан.

## **ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АСУУДАЛ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА, ХАНДЛАГА**

*Судалгааны код:* СТ-10/216  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Б.Ариунжаргал, О.Нарантуяа, Т.Мягмаржав  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ө.Энхтүвшин  
*Огноо:* 2010.06.16  
*Сэдвийн агуулга:* Төрийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх асуудалтай холбоотой ном, материал, судалгааны тайлангуудад анализ хийж, бусад орнуудын туршлага (Австрали улс, Их Британи, Канад улс, АНУ, ОХУ) цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийж, судалгааны материалыг нэгтгэн дүгнэсэн.

## **СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ОНОЛ АРГА ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ЗОХИСТОЙ ХУВИЛБАРУУДЫГ СОНГОХ ЗАРЧИМ**

*Судалгааны код:* СТ-10/217  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
*Огноо:* 2010.06.24



*Сэдвийн агуулга:* Сонгуулийн тогтолцооны онолын үндэслэл, ангилал, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо бүхий улс орны эрх зүйн зохицуулалт (Израиль, Шри Ланка, Ангол, Намиб, Латви, Дани, Финланд, Перу, Парагвай, Гайана, Шинэ Зеланд), Сонгуулийн хүчин зүйлийн нөлөөллийг судалсан. Түүнчлэн Сонгуулийн холимог тогтолцоотой улсуудын судалгаа, Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой улсуудын судалгааг хавсаргав.

### **НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДЛУУД, ӨРГӨН БАРЬСАН ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДЛУУД**

*Судалгааны код:* СТ-10/218  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма, Г.Чулуун, Ш.Хишигсүрэн, Ө.Мөнхтунгалаг, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Батдорж, Ц.Элбэгзаяа, Ц.Батбаяр  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар  
*Огноо:* 2010.07.07  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, Үндсэн хуулийн (1992) зарчимд нийцүүлэн нийслэл хотын статус, онцлох чиг үүрэг, түүний удирдлага, үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, зарим улс орны туршлагыг харьцуулан судалж, санал, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно.

### **ЯПОН БОЛОН ИХ БРИТАНИ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ**

*Судалгааны код:* СТ-10/403  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Б.Хатантуул, Ш.Хишигсүрэн,  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Энхболд  
*Огноо:* 2010.03  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд Их Британи, Япон Улсын Прокурорын байгууллага, түүний тогтолцоон харьцуулалт болон 1990 оноос өмнөх цаазаар авах ялын талаарх хуулийн харьцуулалт, 1987, 2002 оны Эрүүгийн хууль дахь цаазаар авах ялын байдлыг хамруулсан. Түүнчлэн Монгол Улсад цаазаар авах ялыг шүүхээс сүүлийн 40 жилд ногдуулсан байдалд хийсэн судалгааг (1965-2005) <sup>хавсаргав.</sup>

### **ЦААЗААР АВАХ ЯЛЫН БАЙДАЛ, ХАНДЛАГА, БАЙР СУУРЬ**

*Судалгааны код:* СТ-10/404  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Б.Хатантуул, У.Мөнхбат, Ш.Хишигсүрэн, Ю.Эрдэнэтуяа  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Шаравдорж  
*Огноо:* 2010.03.23  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хоёр дахь нэмэлт Протокол, Хүний эрхийн Америкийн конвенцын Протокол, Хүний эрхийн Европын конвенцын 6 дугаар Протокол, Хүний эрхийн Европын конвенцын 13 дугаар Протокол зэрэг Цаазаар авах ялыг халах талаарх олон улсын баримт

бичгүүдийг тусгасан. Мөн Цаазаар авах ялын гүйцэтгэлийг бүс нутгийн байдал, Латин Америкийн улс орнууд зэрэг Цаазаар авах ялын дэлхий нийтийн байдал болон Монгол Улсын хууль тогтоомж дахь ялын дээд хэмжээний талаар, Цаазаар авах ялын талаарх олон нийтийн санаа бодол ямар байгааг багтаасан.

#### **ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭРИЙН ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-10/405  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* К.Пүрэвсүрэн, Б.Хатантуул, Ш.Хишигсүрэн  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ХЗБХ-ны дарга Б.Бат-Эрдэнэ  
*Огноо:* 2010.04.21  
*Сэдвийн агуулга:* Уг мэдээлэл лавлагаанд Үндсэн хуулийн цэц /шүүх, зөвлөл/-ийн шийдвэрийн талаарх Турк, Франц, Испани, Казахстан, Австри, Польш Улсын зохицуулалтуудыг гаргасан.

#### **ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙГ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙГ ХАНГАХ**

*Судалгааны код:* СТ-10/406  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн А.Тлейхан  
*Огноо:* 2010.04.28  
*Сэдвийн агуулга:* Олон улсын эрх зүйн актуудаар тэгш эрх, улс төрийн эрхийн зарчмыг тунхаглаж, үндэстний шинж тэмдгээр ялгаварлан гадуурхахыг хориглосон нь үндэсний цөөнхийн зүгээс тухайн орны голлох үндэстэнтэй адил тэгшээр улс төрийн амьдралд оролцох эрх зүйн тодорхой суурийг бүрдүүлнэ. Гэхдээ энэ нь тухайн улс орон, үндэстэн бүрийн хувьд өөр өөрөөр хэрэгжсээр иржээ.  
Үндэсний цөөнхийн зүгээс улс төрийн амьдралд оролцох эрх зүйн олон төрлийн зохицуулалт байдгаас зөвхөн парламентын сонгуультай холбоотой дараах зохицуулалтын хэлбэрүүд байдаг байна. Үүнд:  
- Сонгуульд оролцоход нь давуу байдал олгох систем,  
- Парламентын суудлын квот тогтоох,  
- Парламентад үндэстнүүдийн төлөөллийн пропорци тогтоох.

#### **МОНГОЛ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХӨГЖИЛ**

*Судалгааны код:* СТ-10/413  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Л.Батжав  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Энхболд  
*Огноо:* 2010.07.23  
*Сэдвийн агуулга:* Өнөөгийн Монголын нутагт Хүннүгийн үеэс Богд хаант улсын үе шувтартал хоёр мянгаад жил (МЭӨ 209 оноос 1924 он) оршин тогтнож байсан феодалын хаант улсуудад төрийн хэргийг хэлэлцэх, хааны эрх мэдлийг зарим талаар хязгаарлах, зөвлөх үүрэг бүхий байгууллагууд байсан түүхэн уламжлал бий. Мэдээлэл лавлагаанд Түүхэн товчоо, Парламентат ёсны төлөвшилтийн талаар өгүүлсэн.

## **ЕВРОПЫН ГИШҮҮН ЗАРИМ УЛСУУДЫН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-10/419

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Л.Батжав, Б.Хатантуул, П.Амаржаргал

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Су.Батболд

*Огноо:* 2010.10.25

*Сэдвийн агуулга:* Захиалгын дагуу Тамгын газрын Судалгааны төвийн ажлын баг нийтдээ Европын 7 орон (Унгар, Дани, Франц, Герман, Ирланд, Испани, Англи улс)-ын орон нутгийн сонгуулийн хууль тогтоомжид агуулгын шинжилгээ хийв.

Европын гишүүн орнууд болох Унгар, Дани, Франц, Герман, Ирланд, Испани, Англи зэрэг долоон улсуудын орон нутгийн сонгуулийн тогтолцоонд улс төрийн намууд хэрхэн оролцох оролцоо, орон нутгийн хурлын үйл ажиллагаанд улс төрийн албан тушаалтнуудыг сонгох, томилох зэргийг /хавсралт-1/ нэр дэвших насны доод хязгаар, улс төрийн нам нэр дэвшүүлэх эрх, (бие даан нэр дэвших эрх) сонгуулийн бүрэн эрхийн хугацаа зэрэг /Хавсралт-2/ судалбал зохих асуудлаар судалгаанд хамрагдсан улс орнуудыг харьцуулан хүснэгтээр харуулахын хамт жишээ болгон Европын холбооноос гишүүн орнуудад гаргасан зөвлөмжийг харгалзан Унгар улсын хувьд дэлгэрэнгүй судалгаа хийв.

Судалгаа хийхдээ тухайн улсын орон нутгийн сонгуулийн хуулийн агуулга, мөн чанар, онцлогийн харьцуулалт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргыг ашиглав.

## **НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ САНАЛ**

*Судалгааны код:* СТ-10/420

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил

*Огноо:* 2010.10.26

*Сэдвийн агуулга:* Судалгаанд нийслэлийн эрх зүйн тухай хуулийн төсөл дэх дүүргийн эрх мэдлийг өргөтгөх асуудлаар судалгаа хийж дүгнэлт хийсэн ба хийхдээ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Нийслэлийн эх зүйн байдлын тухай хууль болон Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн агуулга, мөн чанар, онцлогийн харьцуулалтыг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, бичиг баримтын судалгаа хийв.

## **УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН АСУУДАЛ**

*Судалгааны код:* СТ-10/426

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Л.Батжав

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Я.Батсуурь

*Огноо:* 2010.12.13

*Сэдвийн агуулга:* Дэлхийн бүх орны улс төрийн намын тогтолцоо, гишүүнчлэл, эрх барьж буй нам, хамгийн сүүлд болж өнгөрсөн сонгуулийн асуудлыг

тодорхой хүрээнд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх намуудын дүрмүүдийг нэгбүрчлэн судалсан.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ӨМГӨӨЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ**

*Судалгааны код:* СТ-10/427  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Л.Батжав  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Я.Батсуурь  
*Огноо:* 2010.12.30  
*Сэдвийн агуулга:* Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн гишүүдэд ХБНГУ, ОХУ, Япон, АНУ-ын хуулийг орчуулан судлахын зэрэгцээ захиалга өгсөн асуудлаар өмнө манай улсад хийгдсэн судалгааг ашиглав.

2011 ОН

---

## **ДЭЛХИЙН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАДЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА**

*Судалгааны код:* СТ-11/103  
*Судалгааны төрөл:* Бодлогын судалгаа  
*Судалгааны удирдагч, багийн ахлагч:* Ц.Норовдондог  
*Судалгааг нэгтгэн редакторласан судлаачид:* Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, К.Пүрэвсүрэн  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, П.Амаржаргал, Г.Билгээ, Ц.Болормаа, Б.Буяндэлгэр, Г.Гэрэл, Б.Дуламсүрэн, Б.Мөнхцэцэг А.Пагма, Б.Хатантуул, Б.Цолмонбаяр  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газар (Ерөнхий нарийн бичгийн даргын 251 дүгээр захирамж)  
*Огноо:* 2011.12.23  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд дэлхийн бусад орнуудын парламентын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, бүтцийн нэгжүүдийн чиг үүргийн талаар тив бүрээс сонгосон дэлхийн 50 орчим орныг сонгон авсан болно. Мөн Парламентын ажлын албаны тухай, Судалгааны явцад анхаарал татсан зарим асуудлыг хөндсөний зэрэгцээ Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын талаар мэдээлэл оруулан.  
Дэлхийн бусад орнуудын парламентын ажлын албаны талаарх товч мэдээлэлд парламентын ажлын албаны чиг үүрэг, бүтцийн схем, газар хэлтэс, албадын чиг үүргийн талаар тусгахыг зорьсон болно. Мэдээллийг боловсруулахдаа энэ талаарх ном, товхимол, холбогдох улсуудын Үндсэн хууль, Олон улсын парламентын холбоо, олон улсын бусад байгууллага болон тухайн улсын парламентын болон хууль, эрх зүйн цахим хуудсуудыг ашигласан болно.

## **УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛИЙН 7.1 ДЭХ ХЭСГИЙН ЗААЛТТАЙ ХОЛБООТОЙ ГАДААД ОРНУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-11/201  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* П.Амаржаргал, Ч.Базар, Б.Хатантуул, Ц.Болормаа, Г.Гэрэл  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн  
*Огноо:* 2011.01.07  
*Сэдвийн агуулга:* Судалгааг Австрали, АНУ, БНХАУ, Япон, ОХУ, Франц, Шинэ Зеланд, ХБНГУ, Турк зэрэг есөн улс орны парламентын хуралдааны дэгийг зохицуулсан эрх зүйн актуудын хүрээнд авч үзэж. Мөн Парламентын хэлбэр, байнгын хорооны нээлттэй ба хаалттай болон хосолсон хуралдаантай улс орнуудын судалгааны жагсаалт гаргалаа.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ ДАХ САНХҮҮЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-11/202  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, П.Амаржаргал, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Ганхуяг  
*Огноо:* 2011.01.14  
*Сэдвийн агуулга:* Улс төрийн намуудын санхүүжилттэй холбоотой асуудлаар Эстони, Польш, Молдав, Герман, Эквадор, Турк, Америк зэрэг долоон улсын Улс төрийн намын тухай хууль болон Холбооны Сонгуулийн компани ажлын тухай хуулийн зүйл, заалт дахь намуудын санхүүжилттэй холбоотой асуудлаар судалгаа хийв.

Судалгаанаас үзэхэд улс төрийн намын санхүүжилтийн дараах үндсэн 5 эх үүсвэр байна. Үүнд: гишүүний элсэлтийн хандив болон гишүүний татвар, хуулиар зөвшөөрөгдсөн аж ахуйн үйл ажиллагаа, институционал хандив, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, хувийн хандив, санхүүжилт. Үүний эхний хоёрыг нь намын өөрийн санхүүжилт гэж үзэх бөгөөд гишүүний татвар, хандив ба институционал хандивыг намын уламжлалт санхүүжилт гэж үздэг. Хөгжлийн явцад санхүүжилтийн дээрх эх үүсвэрүүдийн заримынх нь үүрэг багасч, зарим нь нэмэгдэж байна. Тухайлбал, уламжлалт санхүүжилтийн хэмжээ улам бүр багасах буюу алга болж байна.

## **ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭ, ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-11/203  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Мягмарцэрэн, Г.Билгээ, Ц.Батбаяр, Ц.Болормаа, Г.Гэрэл, Ц.Элбэгзаяа, Ч.Онончимэг  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Бямбацогт  
*Огноо:* 2011.01.21  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтын талаархи эрх зүйн зохицуулалт, энэ талаарх бусад орнуудын туршлага, хуулийн төсөлд хийсэн шинжилгээ гэсэн үндсэн хэсгүүдтэй.

Судалгаанд жишээ болгон 20 орчим орныг сонгон авч харьцуулан судалсан. Эдгээрийг сонгохдоо манай улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлж байгаа улс орнууд, мөн гадны хөрөнгө оруулалтаар эдийн засгаа хөгжүүлсэн туршлага бүхий улс орнууд, эдийн засгийн өсөлт, хөгжлөөр манай улстай ойролцоо улс орнууд гэсэн шалгуурыг үндэслэсэн.

Судалгааны үр дүнд манай улсад оруулж буй гадны хөрөнгө оруулалтаас хүртэх үр ашгийг дээшлүүлэхийн зэрэгцээ үндэсний аюулгүй байдал болон дотоодын эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөхүйц эрсдэл ба үүнээс сэргийлэх арга замуудыг тодорхойлохыг зорьсон болно. Судалгааны үр дүн, бусад орнуудын туршлагад тулгуурлан Монгол Улсын стратегийн ач холбогдолтой салбарууд, тэдгээрийг тодорхойлсон байдал, хууль эрх зүйн хүрээнд тавьсан хязгаарлалт, хориглолт бий эсэх, хэрэгжүүлэх боломж, механизм нь ямар байгаа талаар харьцуулан судлав.

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 34.3 ДАХЬ ЗААЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙНТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-11/204  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Ц.Товуусүрэн, Г.Алтан-Оч, Ч.Базар, Б.Мөнхцэцэг  
*Захиалагч:* УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хороо, УИХ-ын Тамгын газрын Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтэс  
*Огноо:* 2011.01.31  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн УИХ-ын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь заалтад нэмэлт оруулахаар УИХ-ын гишүүн Э.Бат-Үүлийн өргөн барьсан төсөлтэй холбогдуулан хийсэн судалгаа. Судалгаад АНУ, ОХУ, Австрали, Франц, Унгар, Герман, Украин, Киргиз, Литв, Латв, Эстони, Румын, Гүрж зэрэг 13 улсын парламентын гишүүдийн халдашгүй эрхийн талаар харьцуулан судалсан.

### **УЛС ТӨРИЙН НАМУУДЫН БҮТЭЦ, ГИШҮҮНЧЛЭЛ, САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-11/207  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Б.Буяндэлгэр, Ц.Товуусүрэн, П.Амаржаргал, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ш.Сайхансамбуу  
*Огноо:* 2011.02.25  
*Сэдвийн агуулга:* Судалгааны зорилго нь судалгаанд хамрагдсан орнуудын Үндсэн хууль, улс төрийн намын тухай хууль, зарим намын дүрэм зэргийг нэг бүрчлэн судлаж, тухайн орнуудад улс төрийн намын бүтэц, гишүүнчлэл, санхүүжилтийн асуудлыг хэрхэн зохицуулсныг харьцуулж, нийтлэг чиг хандлагыг захиалагчид мэдээлэх явдал юм. Харьцуулсан судалгаанд Орос, Нидерланд, Швед, Герман, Япон, Америк зэрэг Гадаадын зарим орнуудын туршлагыг оруулсан.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН “ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙГ ХУУЛЬ БУСААР АВАХ” ГЭМТ ХЭРЭГ, “ГЭМТ ХЭРЭГТ ХАМТРАН ОРОЛЦОХ” ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-11/208  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, П.Амаржаргал, О.Нарантуяа, Б.Ариунжаргал, Ө.Мөнхтунгалаг, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл, ЭЗХТХ-ийн дарга Д.Насанжаргал  
*Огноо:* 2011.03.15  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд ХБНГУ, ОХУ, АНУ, БНСУ, Япон улсын Эрүүгийн хуулийн “Гэмт хэрэгт хамтран оролцох”, “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах” зэрэг гэмт хэргүүдийн ойлголт, эрх зүйн зохицуулалт болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн зохих зүйл, заалтыг судласан.

## **ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГА БА ПАРЛАМЕНТЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ОНЦЛОГ (ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЧИГ ХАНДЛАГА)**

*Судалгааны код:* СТ-11/210  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа, О.Нарантуяа  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
*Огноо:* 2011.04.01  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд Парламентын сэтгүүл зүй, түүний онцлог, Парламентын мэдээллийн орчин, Парламентын хуралдааны хэлбэр, Парламентын мэдээллийг түгээх стратеги, Парламентын сэтгүүлчдэд хориглох зүйл, тавигдах шаардлага, сэтгүүлчдийн ёс зүйн зарчим, Парламентын хэвлэл мэдээллийн албанаас сэтгүүлчидтэй харилцах, Парламентын мэдээллийг олон нийтэд хүргэх аргууд, Парламентын хэвлэл мэдээллийн алба ба парламентын сэтгүүлчдийн мэдээлэл, Монгол Улсын парламентын мэдээллийн үйл ажиллагаа зэрэг асуудлуудаар судалгаа хийсэн.  
Австрал, АНУ, БНСУ, Польш, Франц зэрэг орны парламентын мэдээллийг олон нийтэд хүргэх туршлагыг хавсаргасан.

## **ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-11/211  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, Б.Буяндэлгэр, Т.Мягмаржав, О.Нарантуяа, Н.Түвшинтөгс  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Эрдэнэ  
*Огноо:* 2011.04.11  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаанд ялтны хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг юуны өмнө ялтныг нийгэмшүүлэх зорилго бүхий албадан бус хөдөлмөр гэсэн талаас нь авч үзэж, гадаадын хэд хэдэн орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзлээ. Дашрамд дурдахад манай улсад ялтны хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг нилээн нарийн зохицуулсан байдаг. АНУ, ОХУ, ХБНГУ, БНСУ, Япон зэрэг улсуудын ялтны

хөдөлмөрийн эрх зүйн харилцааг зохицуулж буй хууль тогтоомж болон зарим туршлагаудын талаар харьцуулан судалсан.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОЁР ТАНХИМТАЙ ПАРЛАМЕНТЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

|                             |   |
|-----------------------------|---|
| <i>Судалгааны код:</i>      | СТ-11/212   |
| <i>Судалгааны төрөл:</i>    | Харьцуулсан судалгаа  |
| <i>Гүйцэтгэсэн судлаач:</i> | Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, Б.Буяндэлгэр, П.Амаржаргал, Б.Ариунжаргал, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, О.Нарантуяа, Б.Хатантуул, А.Пагма  |
| <i>Захиалагч:</i>           | УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв   |
| <i>Огноо:</i>               | 2011.04.20  |
| <i>Сэдвийн агуулга:</i>     | Хоёр танхим бүхий парламенттай орнуудын парламентын эрх зүйн зохицуулалт, дээд болон доод танхим байгуулагдах хэлбэр, танхим хоорондын харилцаа, сонгогдох болон томилогдох хэлбэр, хууль тогтоох үйл ажиллагааны процедур, тухайн орны засаглалын болон парламентын тогтолцооны онцлог зэргийг харьцуулан судлав. Судалгаанд доор дурдсан нийт 5 тивийн 56 орны парламентын холбогдох эрх зүйн зохицуулалтыг оруулсан. Үүнд: <ol style="list-style-type: none"><li>1. Австрали, зарим далайн орнууд - нийт 3 улс,</li><li>2. Ази тив - нийт 16 улс,</li><li>3. Африк тив - нийт 12 орон,</li><li>4. Америк тив - нийт 10 орон,</li><li>5. Европ тив - нийт 15 улс.</li></ol> |

## **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

|                             |  |
|-----------------------------|--|
| <i>Судалгааны код:</i>      | СТ-11/213  |
| <i>Судалгааны төрөл:</i>    | Харьцуулсан судалгаа   |
| <i>Гүйцэтгэсэн судлаач:</i> | Ч.Базар /Ph.D/   |
| <i>Захиалагч:</i>           | УИХ-ын гишүүн Я.Батсуурь   |
| <i>Огноо:</i>               | 2011.04.22   |
| <i>Сэдвийн агуулга:</i>     | Мэдээллийн аюулгүй байдал, түүнийг хамгаалах нь өргөн хүрээний асуудал юм. Мэдээллийн аюулгүй байдлын цаана улс орны Үндэсний аюулгүй байдлын асуудал оршиж байна. |

Судалгааны хүрээнд Үндэсний аюулгүй байдал ба мэдээллийн эрх чөлөө, Үндэсний аюулгүй байдал ба төрийн нууц, мэдээллийн аюулгүй байдлыг яагаад хангах нь чухал, энэ талаар юу хийвэл зохих талаар асуудал дэвшүүлэн тавьдаг мэргэжлийн хүмүүс, судлаачид, эрдэмтэн судлаачид, энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын мэдээлэл, судалгаан дээр үндэслэн товч мэдээллийг бэлтгэв.

Мөн улс орнууд мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд төрийн нууц, хувь хүний мэдээллийг хэрхэн хамгаалдаг, ямар тохиолдолд ил болгодог, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс ямар үүрэг хариуцлагатай ажилладаг зэргийг пост коммунист байсан зарим орон, АНУ, Австрали, ИБУИВУ, ХБНГУ, БНСУ зэрэг орнуудын зарим эрх зүйн зохицуулалтаас товчлон бэлтгэв. Олон улсад ямар зарчим дээр үндэслэн эрх зүйн орчноо бүрдүүлдгийг мөн жишээлэв.



## **ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД УЛС ТӨРИЙН НАМУУД ОРОЛЦОХ НЬ**

*Судалгааны код:* СТ-11/215  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, Б.Ариунжаргал, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, О.Нарантуяа, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Су.Батболд  
*Огноо:* 2011.05.23  
*Сэдвийн агуулга:*

Дэлхий дахины нийгмийн хөгжлийн орчин үеийн түвшинд орон нутгийн өөрийн удирдлагын янз бүрийн загварууд байдаг. Тухайн загварын хүрээнд төлөөллийн байгууллага нь ямар эрх хэмжээний хүрээнд ажилладаг, орон нутгийн сонгогдох зарчмын талаар бидний хийсэн судалгаа тодорхой ойлголтыг өгнө гэдэгт найдаж байна.

Энэхүү судалгааг хийхдээ Казахстан, Унгар, Канад, Чили, Испани, Франц, Словени, Шинэ Зеланд, БНСУ-ын орон нутаг, мужийн сонгуулийн тойргийн талаар болон тойрогт намаас нэр дэвшүүлэх, намуудын сонгуулийн сурталчилгаа, намын ажиглагчид сонгуульд хэрхэн оролцдог талаар харьцуулан судалсан болно.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН БОЛОН СОНГУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ХОРООНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-11/216  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, П.Амаржаргал, Ч.Базар, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ж.Сүхбаатар  
*Огноо:* 2011.05.25  
*Сэдвийн агуулга:* Европын Парламент, ХБНГУ, Австрали, БНЭУ-ын парламентын Өргөдөл, гомдлын хорооны дүрэм, чиг үүрэг болон ХБНГУ, Шинэ Зеланд, Филиппин, АНУ-ын парламентын сонгуулийн асуудал хариуцсан хорооны чиг үүрэг талаар харьцуулан судалсан.

## **СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААРХ ГАДААД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-11/221  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Б.Буяндэлгэр, П.Амаржаргал, Б.Цолмонбаяр, К.Пүрэвсүрэн  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин  
*Огноо:* 2011.10.05  
*Сэдвийн агуулга:* Захиалгын дагуу “албан тушаалтан хууль ёсны орлогоос нь их хэмжээгээр илүү гарсан хөрөнгийг хэрхэн олж авсан талаар үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй бол” гэсэн үйл явцыг бусад улс орнуудын Эрүүгийн хууль болон холбогдох хууль тогтоомжинд хэрхэн тусгасныг харьцуулан судлав. Тус судалгаанд АНУ, ХБНГУ, Япон улс, ОХУ, БНХАУ, Пост коммунист орнуудыг хамруулсан болно.

## **ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫГ ЦУЦЛАХ, БҮРЭН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

|                             |   |
|-----------------------------|---|
| <i>Судалгааны код:</i>      | СТ-11/222   |
| <i>Судалгааны төрөл:</i>    | Харьцуулсан судалгаа  |
| <i>Гүйцэтгэсэн судлаач:</i> | Б.Буяндэлгэр, Г.Алтан-Оч, П.Амаржаргал, Г.Билгээ, Ц.Болормаа, Г.Гэрэл, О.Нарантуяа, Б.Хатантуул, А.Пагма  |
| <i>Захиалагч:</i>           | УИХ-ын гишүүн Су.Батболд  |
| <i>Огноо:</i>               | 2011.10.05  |
| <i>Сэдвийн агуулга:</i>     | Парламентын гишүүдийн халдашгүй байдлыг цуцлах, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх асуудлыг Америк, Испани, Австрали, Бельги, Герман, Дани, Хятад, Ирланд, Франц, Литва, Эстони, Орос, Өмнөд Солонгос, Япон зэрэг орнуудын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалтыг эх хэлнээс нь албан бусаар орчуулж, зарим тодруулгын хамт хүснэгтээр харьцуулан үзүүллээ. |

## **УНИТАРУЛСУУДЫН ПАРЛАМЕНТЫН БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУ ГАЦАА, ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ТООГТОГТООХ ЖИШИГ**

|                             |   |
|-----------------------------|---|
| <i>Судалгааны код:</i>      | СТ-11/225   |
| <i>Судалгааны төрөл:</i>    | Харьцуулсан судалгаа  |
| <i>Гүйцэтгэсэн судлаач:</i> | Р.Хатанбаатар, А.Пагма, Б.Цолмонбаяр  |
| <i>Захиалагч:</i>           | УИХ-ын гишүүн Н.Батбаяр   |
| <i>Огноо:</i>               | 2011.10.26  |
| <i>Сэдвийн агуулга:</i>     | Дэлхийн унитар тогтолцоотой улс орнуудыг дараах байдлаар бүлэглэн парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт, статистик мэдээлэлийг харьцуулсан. Үүнд <ul style="list-style-type: none"><li>- унитар зарим орнуудын парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт, статистик мэдээлэл – нийт 70 улс,</li><li>- 1-5 сая хүн амтай улсын парламентын холбогдох эрх зүйн зохицуулалт, статистик мэдээлэл – нийт 20 улс,</li><li>- парламентын болон орон нутгийн сонгуулийн хуулийн судалгаа – нийт 20 улс.</li></ul> |

## **СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООТ УЛС ОРНУУДЫН СОНГОГЧДЫН САНАЛ ГАРГАХ ХУВИЛБАРУУД**

|                             |   |
|-----------------------------|---|
| <i>Судалгааны код:</i>      | СТ-11/228   |
| <i>Судалгааны төрөл:</i>    | Харьцуулсан судалгаа  |
| <i>Гүйцэтгэсэн судлаач:</i> | Ц.Товуусүрэн, Ц.Болормаа, Г.Гэрэл, О.Нарантуяа, Б.Хатантуул   |
| <i>Захиалагч:</i>           | УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн   |
| <i>Огноо:</i>               | 2011.12.06  |
| <i>Сэдвийн агуулга:</i>     | Сонгуулийн холимог тогтолцоо: нь олонхийг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах /пропорциональ/ тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг. Сонгуулийн холимог тогтолцооны хувилбарыг дэлхийн 30 шахам орнуудад ашигладаг. Ер нь холимог тогтолцоог ихэнх тохиолдолд газар нутгийн хэмжээ томтой, олон хүн амтай, олон үндэстэн ястан оршин суудаг, бүс нутгийн болон үндэстний эрх ашгийг төлөөлөх зайлшгүй шаардлагатай улс орнууд сонгосон байдаг. |

Судалгаанд сонгуулийн холимог тогтолцоо бүхий 24 орныг хамруулсан ба эдгээр орноос сонгогчид санал өгөх субъектээр нь ангилсан санал хураалтын арга зам бүхий 3 хүснэгтийг тойргийн

хэлбэр болон хувь тэнцүүлэн хуваарилахад ногдох суудал зэрэг мэдээллийг багтаан доор хавсаргав.

## **ГАДААД ОРНУУДЫН ПАРЛАМЕНТ ДАХ СОНГОГЧДЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН ДЭД ХОРОО**

*Судалгааны код:* СТ-11/402  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, Ц.Болормаа, Г.Гэрэл, О.Нарантуяа, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ж.Сүхбаатар  
*Огноо:* 2011.01.14  
*Сэдвийн агуулга:* Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.1.3-т Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнд Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэл хяналтын дэд хороог байгуулсан бөгөөд гадаад орнуудын парламентад ижил төстэй Дэд болон Байнгын хороо байдаг эсэх, ямар бүтэцтэй, ямар дүрэм, журмаар үйл ажиллагааг нь зохицуулдаг талаарх харьцуулсан мэдээллийг гаргав. Судалгаанд Турк, Ирак, Кувейт, Шинэ Зеланд, Египт, Замби, Дани, Испани, Португали, Швед, Герман зэрэг 11 орныг хамруулан мэдээллийг хүснэгтээр бэлтгэлээ.

## **ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХҮСНЭГТЭН ЛАЛАГАА**

*Судалгааны код:* СТ-11/404  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* П.Амаржаргал  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил  
*Огноо:* 2011.02.25  
*Сэдвийн агуулга:* УИХ-ын чуулганы 2010.06.10-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан юм. Энэ хуульд оруулсан зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлт түүний хэрэгжилтэнд хяналт тавихад тусламж болгох хүрээнд хүснэгтэн лавлагаа мэдээлэлийг гаргав.Зарчмын шинжтэй 12 нэмэлт, өөрчлөлтыг хүснэгтэд тусгав.

## **ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДЛААР ӨДӨР ТУТМЫН ХЭВЛЭЛҮҮДИЙН НИЙТЛЭЛД ХИЙСЭН КОНТЕНТ-АНАЛИЗ**

*Судалгааны код:* СТ-11/405  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ж.Алтанцэцэг, Б.Ариунжаргал, Ө.Мөнхтунгалаг, Б.Мөнхцэцэг, Т.Мягмаржав, Р.Нургуль, М.Оюунтулга, Ц.Янжинцэрэн  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн  
*Огноо:* 2011.03.21  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд дараах өдөр тутмын хэвлэлийг сонгон авч нийтлэгдсэн 448 материалд хэвлэгдсэн санал шүүмжлэлийг түүвэрлэн авч хүснэгтээр гаргасан.  
1. Үнэн, 1999.01-2011.03,  
2. Монголын үнэн, 1999.01-2011.03,  
3. Зууны мэдээ, 1999.01-2011.03,  
4. Зууны шуудан, 2007.01-2011.02

5. Үндэсний шуудан, 2007.01-2011.02
6. Өдрийн сонин, 1999.01-2011.03
7. Өнөөдөр, 1999.01-2011.03
8. Нийгмийн толь,
9. Ардчилал,
10. Ардын эрх, 2005-2011.03

Эдгээр нийтлэгдсэнээс Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэсэн санал шүүмжлэл 154 буюу 34,3%, 2000 оны нэмэлт өөрчлөлт оруулахыг буруу гэсэн санал шүүмжлэл 183 буюу 40,8%, Үндсэн хуулийг шинээр дахин бичих нь зүйтэй гэсэн санал шүүмжлэл 6 буюу 1,5%, бусад санал шүүмжлэл, мэдээлэл 105 буюу 23,4% нийтлэгджээ.

### **ҮНДЭСНИЙ ХОРОО, ЗӨВЛӨЛҮҮДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЭРХ ЗҮЙН СТАТУС, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-11/407  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ж.Алтанцэцэг, Б.Ариунжаргал, Ө.Мөнхтунгалаг, Б.Мөнхцэцэг, Т.Мягмаржав, Р.Нургуль, М.Оюунтулга, Ц.Янжинцэрэн  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, НББСШУБХ-ны дарга Д.Очирбат  
*Огноо:* 2011.04.21  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд УИХ-ын тогтоолоор байгуулагдсан үндэсний зөвлөл(3), Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан “байнгын” ажиллагаатай үндэсний зөвлөл (14), үндэсний хороо (3), мөн тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн Газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах “орон тооны бус”үндэсний зөвлөл (22), үндэснийхороо (13), нийт 55 хороо, зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, зөвлөлийн бүрэлдэхүүн, холбогдох хуулийн заалт, эрх зүйн статус зэргийг тусгасан болно.

### **СОНГОГЧДИЙН ИРЦ, САНАЛЫН БОСГЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-11/409  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Ц.Товуусүрэн, Ц.Болормаа, Б.Хатантуул, Ө.Мөнхтунгалаг  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ж.Сүхбаатар  
*Огноо:* 2011.05.02  
*Сэдвийн агуулга:* Судалгаа нь харьцуулсан мэдээлэл бүхий хоёр хүснэгтээс бүрдэнэ. Нэгдүгээр хүснэгтэд дэлхийн 54 орны парламентын (2танхимтай парламентын хувьд доод танхим) гишүүдийн тоо, сонгуулийн тогтолцоо, сонгууль хүчинтэйд тооцох сонгогчдын ирц болон саналын босгын талаарх мэдээллийг харьцуулан нэгтгэсэн юм. Хоёрдугаар хүснэгтийн хувьд 185 орны сүүлчийн сонгуулийн ирцийн сонгогчдын мэдээллийг багтаасан байна.

## **ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ЗАРЧИМ**

*Судалгааны код:* СТ-11/410  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Ц.Товуусүрэн, Ц.Болормаа, Б.Хатантуул, Ө.Мөнхтунгалаг  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн  
*Огноо:* 2011.06.06  
*Сэдвийн агуулга:* Судалгааг хийхэд судалгаанд хамрагдсан 46 улс орнуудын Үндсэн хуульд байгаа заалтад ихэвчлэн суурилсан бөгөөд зарим нэг улс орны хувьд Парламентын тухай болон сонгуулийн тухай хуулиас холбогдох заалтыг авч үзсэн болно.

## **АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА**

*Судалгааны код:* СТ-11/414  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, П.Амаржаргал  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн  
*Огноо:* 2011.07.01  
*Сэдвийн агуулга:* “Ард нийтийн санал асуулга” нь бусад улс оронд ямар асуудлаар хэрхэн яаж шийдвэрлэхийг харьцуулан лавлагаа мэдээлэл гаргалаа. Үүнд: Итали улс, Сингапур улс, Австрали улсын ард нийтийн санал асуулгыг харьцуулан авч үзлээ.

## **ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-11/416  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Мягмарцэрэн  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Э.Мөнх-Очир  
*Огноо:* 2011.08.10  
*Сэдвийн агуулга:* ОХУ-ын Үндсэн хуулиар хэн эзэмшиж байгаагаас үл хамааран өмчийн бүх хэлбэр эрх тэгш байхаар заасан байдаг. Харин төрийн өмчийн тухай ойлголт нь эдийн засгийн харилцаанд онцлог шинж чанартай байдаг. Учир нь Төр эдийн засгийн харилцаанд хоёр талтайгаар оролцдог. Нэгдүгээрт, төр өөрийн бүрэн эрхийн дагуу эдийн засгийн харилцаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн актуудыг батлан гаргах замаар эдийн засгийн харилцааг зохицуулах байдлаар оролцдог. Хоёрдугаарт, эдийн засгийн хаилцаанд өөрийн эзэмшил ашиглалд буй материаллаг болон материаллаг бус эд хөрөнгийн үндсэн дээр улс орны нийгэм эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх үүрэг бүхий оролцогч нь болдог.

## **УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛ, ТӨЛӨВШИЛ, НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН СОНГУУЛЬ, ПАРЛАМЕНТ БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙГ ЗЭРЭГ ЯВУУЛАХ НЬ**

*Судалгааны код:* СТ-11/420  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Базар, П.Амаржаргал, Б.Цолмонбаяр, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Ганхуяг  
*Огноо:* 2011.10.31

**Сэдвийн агуулга:** Судалгаанд улс төрийн намын гишүүнчлэлийн талаар, хэт улс төржилт ямар, ямар хүчин зүйлүүдээс шалтгаалж буй талаар, нутгийн өөрөө удирдах байгууллагыг хэрхэн сонгодог талаар, орон нутгийн болон УИХ-ын сонгуулийг хамт явуулдаг орнуудын талаар судалсан. Мөн Болгар, Индонез, Тайвань, АНУ, Австрали зэрэг орны парламент, орон нутгийн сонгуулийг зэрэг явуулдаг мэдээллийг хавсаргав.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ШАГНАЛЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

**Судалгааны код:** СТ-11/421  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** А.Пагма, Г.Гэрэл  
**Захиалагч:** УИХ-ын дарга Д.Дэмбэрэл  
**Огноо:** 2011.11.18  
**Сэдвийн агуулга:** Уг мэдээлэл лавлагаанд Австри улсын Ардчиллын шагнал (The Democracy Award), Шинжлэх ухааны шагнал (The Science Award), Хорват улсын Амьдарлын амжилтын шагнал, Оны шилдэг шинжлэх ухааны шагнал, Оны шилдэг шинжлэх ухааны дэмжлэгийн шагнал, Оны шилдэг залуу судлаачдын шагнал болон АНУ-ын Конгрессын Алтан Медаль (Congressional Gold Medal), Конгрессын Алтан Медалиар шагнах шалгуур, журам зэргийг хамруулан судалсан.

## **ЗАРИМ УЛС ОРНУУД ДАХЬ СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-11/423  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, А.Пагма, Ц.Болормаа  
**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн  
**Огноо:** 2011.12.05  
**Сэдвийн агуулга:** Энэхүү мэдээлэл лавлагаанд Шинэ Зеландын сонгуулийн хуулийн зарим зохицуулалт, тухайлбал, сонгуулийн систем, сонгогч санал гаргах, санал тоолох, суудал хуваарилах, ХБНГУ-ын сонгуулийн хуулийн сагал гаргах, саналын дүнг нэгтгэх талаарх эрх зохицуулалт, Румын улсын сонгуулийн системийн талаар судалсан.

## **ДЭЛХИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО**

**Судалгааны код:** СТ-11/424  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Т.Мягмаржав, Ч.Базар  
**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
**Огноо:** 2011.12.23  
**Сэдвийн агуулга:** Тус судалгааны ажилд эмэгтэйчүүдийн квотын тухай ерөнхий ойлголт, хэрэгжилт, үр дүн болон дэлхийн хичнээн орны хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаархи ерөнхий мэдээлэл болон квотыг хэрэгжүүлж буй улс орнуудын туршлага, түүнчлэн амжилтанд хүрсэн дэлхийн эмэгтэй улс төрчдийн улс төрийн амьдралд учирч байсан саад бэрхшээл, ололт амжилт, улс төрийн зоримог шийдлүүдийн талаархи харьцуулсан мэдээлэл багтсан болно.

Түүнчлэн 80 орны холбогдох хууль тогтоомж дахь квотын талаарх мэдээллийг түүвэрлэн оруулав.

### **УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

*Судалгааны код:* СТ-11/505  
*Судалгааны төрөл:* Дүн шинжилгээ  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
*Огноо:* 2011.10.21  
*Сэдвийн агуулга:* Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн анхны хэлэлцүүлэг хийсний дараах төсөлд шинжилгээ хийж, найруулгын болоод бусад хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн зүйл заалтаар дор дурдсан зөвлөмжийг гаргаж байна. Энэхүү зөвлөмжид Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн болон шийдвэрлэх зарчмын асуудлыг хөндөөгүй болно.

## **2012 ОН**

---

### **“УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙГ ХАМТАД НЬ ЯВУУЛАХ БОЛОМЖТОЙ ЭСЭХ АСУУДАЛ”-ААР ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА БОЛОН МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-12/201  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Б.Цолмонбаяр, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар  
*Огноо:* 2012.01.27  
*Сэдвийн агуулга:* “Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулийг хамтад нь явуулах боломжтой эсэх” сэдвийн хүрээнд парламент, орон нутгийн сонгуулийг зэрэг явуулдаг зарим орны мэдээлэл, манай улстай хүн амын хувьд ойролцоо унитар тогтолцоотой улс орнуудын жишиг, мөн түүнчлэн сонгуулийг хамт явуулахын эерэг болон сөрөг үр дагаварын талаар судалгаа хийхийг хүссэн захиалгыг хүлээн авч сонгуулийг хамтад нь явуулдаг 6 орон мөн түүнчлэн манай улстай адил төстэй 20 унитар улс орны жишээг хамруулан судлаачдын баг захиалгыг гүйцэтгэв.

### **НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМЫН ОРОЛЦОО, ҮҮРЭГ, НӨЛӨӨ, ГИШҮҮДИЙН ОРОН НУТГИЙН ХУРАЛД НЭР ДЭВШИХ ЭРХ, УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТУХАЙ**

*Судалгааны код:* СТ-12/202  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* П.Амаржаргал, К.Пүрэвсүрэн  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Г.Батхүү  
*Огноо:* 2012.02.29

*Сэдвийн агуулга:* Уг судалгааг Австри, Австрали, АНУ, Герман, Дани, Ирланд, Испани, Их Британи, Казахстан, Канад, Мексик, Молдов, Нидерланд, ОХУ, Польш, Словени, Солонгос, Унгар, Франц, Чили, Швед, Швейцарь, Эстони, Япон зэрэг улсуудын Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуульд нэр дэвшүүлэх тухай, Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийн тухай, Орон нутгийн сонгууль болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаан дахь улс төрийн намуудын оролцоо, улс төрийн намуудын гишүүнчлэлийн асуудлаар Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, мэдээлэл, судалгааны материалд үндэслэн хийсэн болно.

### **ОЛОН НИЙТИЙГ ХАМАРСАН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЖИШИГ ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-12/204  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма, Б.Цолмонбаяр, П.Амаржаргал, Б.Хатантуул, Г.Билгээ  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батбаяр  
*Огноо:* 2012.04.10  
*Сэдвийн агуулга:* Уг сэдвийн хүрээнд Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг зохицуулах олон улсын эрх зүйн баримт бичгүүд, тухайн нөхцөл байдал үүссэн үеийн эрх зүйн зохицуулалт, бусад орнуудын практик болон АНУ, Франц, Мексик, Япон, Унгар улсын жагсаал, цуглаан, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг зохицуулах эрх зүйн зохицуулалт, 1911 оноос хойших Монгол Улсын улс төрийн сонгуулийн болон олон нийтийн санал асуулгын түүхэн лавлагааг хүргүүлсэн байна.

### **ПАРЛАМЕНТЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЖ БҮЙ МЭРГЭШСЭН ҮЙЛЧИЛГЭЭ**

*Судалгааны код:* СТ-12/211  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Мягмарцэрэн, П.Амаржаргал, Г.Билгээ, Б.Дуламсүрэн  
*Захиалагч:* УИХ-ын дарга Д.Дэмбэрэл  
*Огноо:* 2012.03.16  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь “Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд ажлын албанаас үзүүлж буй мэргэшсэн үйлчилгээ” гэсэн тодорхой хүрээгээр хязгаарлагдаж байгаа тул Парламентын хууль тогтоохоос бусад эрх мэдлийн талаар авч үзээгүй болно. Тиймээс судалгаанд хамрагдсан 50 орчим орны Парламентын ажлын албаны хууль эрх зүйн болон хуралдаан зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгжүүдийн зохион байгуулалт, чиг үүрэг нь УИХ-ын Тамгын газар дахь ижил чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдэд хэрхэн зохион байгуулагдсан талаар харьцуулан авч үзлээ.

### **ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЖ БҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ**

*Судалгааны код:* СТ-12/212  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа



*Гүйцэтгэсэн судлаач:* А.Пагма, Г.Гэрэл, Б.Мөнхцэцэг  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газар  
*Огноо:* 2012.03.16  
*Сэдвийн агуулга:* Шинэ Зеланд, Их Британи, Герман зэрэг улсын Парламентын хяналт, шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд Ажлын албанаас үзүүлж буй үйлчилгээний талаар харьцуудан судалсан.

#### **ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ НЭГЖҮҮДИЙН ТУХАЙ**

*Судалгааны код:* СТ-12/213  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Пүрэвсүрэн, Т.Мягмаржав  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газар  
*Огноо:* 2012.03.16  
*Сэдвийн агуулга:* Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, Олон нийттэй харилцах үйл ажиллагаа, Радио, телевиз /broadcasting/, Парламентын боловсрол зэрэг асуудлын хүрээнд судалсан. Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын ажлын албаны зохион байгуулалт болон хэрэгжүүлэх чиг үүргээс харахад ихэнх улсын хувьд Хэвлэл мэдээллийн болон Олон нийттэй харилцах нэгж нь хамтдаа байх тул энэхүү нэгжийн талаарх мэдээллийг нэгтгэн бичив. Харин бусад нэгжийн хувьд тус тусад нь, нийтлэг болон онцлог байдлыг дүгнэн оруулсан ба зарим нэг онцлог зохион байгуулалттай улсуудыг жишээ болгон оруулав.

#### **ПАРЛАМЕНТАД АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЖ БҮЙ СУДАЛГАА, АРХИВ, НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

*Судалгааны код:* СТ-12/214  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Болормаа, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газар  
*Огноо:* 2012.03.16  
*Сэдвийн агуулга:* Хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, Олон нийттэй харилцах үйл ажиллагаа, Радио, телевиз /broadcasting/, Парламентын боловсрол зэрэг асуудлын хүрээнд судалсан. Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын ажлын албаны зохион байгуулалт болон хэрэгжүүлэх чиг үүргээс харахад ихэнх улсын хувьд Хэвлэл мэдээллийн болон Олон нийттэй харилцах нэгж нь хамтдаа байх тул энэхүү нэгжийн талаарх мэдээллийг нэгтгэн бичив. Харин бусад нэгжийн хувьд тус тусад нь, нийтлэг болон онцлог байдлыг дүгнэн оруулсан ба зарим нэг онцлог зохион байгуулалттай улсуудыг жишээ болгон оруулав.

#### **ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ ДЭХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-12/215  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Алтан-Оч, С.Дорждагва  
*Захиалагч:* Судалгааны төв  
*Огноо:* 2012.03.16

*Сэдвийн агуулга:*

Тус судалгааны ажилд хамруулан авч үзсэн 50 орчим улс орнуудын парламентын ажлын албаны бүтцээс харахад эдгээр гурван чиг үүрэг нэг хэлтэс, албанд нэгтгэгдсэн, эсвэл тус тусдаа алба болгосон олон төрлийн хэлбэртэй байна. Гэхдээ, нэг ерөнхий чиг хандлага ажиглагдаж байгаа нь мэдээллийн технологийг гүнзгий нэвтрүүлж парламентын үйл ажиллагаан дахь автоматжуулалтын түвшин нэмэгдэхийн хэрээр эдгээр чиг үүргийг дагнан хариуцсан бие даасан хэлтэс байдалтай болж байна. Мөн, хөгжиж байгаа орнуудад эдгээр чиг үүрэг нэг хэлтэст харъяалагдаж байгаа бол хөгжлийн түвшин нэмэгдэхийн хэрээр бие даасан хэлтэс болж хөгжиж байна. Үлгэр жишээ болохуйц зарим орны Тамгын газрын бүтцийг хавсаргав. Үүнд: Норвеги, Нидерланд, Герман (Хавсралт №1-3).

### **ТӨРИЙН АЛБАНЫ ТОГТОЛЦОО, ШИНЭТГЭЛИЙН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

*Судалгааны код:* СТ-12/220

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Ц.Товуусүрэн, Ө.Мөнтунгалаг, Ц.Болормаа, Б.Нарантуяа

*Захиалагч:* ТББХ-ны дарга А.Бакей

*Огноо:* 2012.09.24

*Сэдвийн агуулга:* Монгол Улсын төрийн албаны тогтолцоо, бүтцийн схемийг гадаадын зарим орнуудынхтай харьцуулж, төрийн албаны шинэтгэлийн бодлого, хууль, эрх зүйн орчны ижил төсөөтэй болон ялгаатай байдлын талаар дүн шинжилгээ хийж тулгамдсан асуудлыг тодруулах, цаашид төрийн албаны шинэтгэлийг оновчтой явуулах бодлогын хувилбаруудын эерэг сөрөг талыг гаргаж тавин хууль тогтоогчдод сонголт хийх боломж олгох зорилго тавин ажиллав.

### **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ӨРГӨДЛИЙН ХОРООДЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-12/221

*Судалгааны төрөл:* Дүн шинжилгээ

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, А.Пагма, Б.Нарантуяа, Ө.Мөнхтунгалаг

*Захиалагч:* УИХ-ын Өргөдлийн Байнгын хорооны дарга Р.Бурмаа

*Огноо:* 2012.10.05

*Сэдвийн агуулга:* Гадаадын зарим орны, тухайлбал, Австрали, ХБНГУ, БНЭУ-ын Өргөдлийн хороодын чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг судалж, туршлагыг харьцуулан гаргахын тулд эдгээр орнуудын парламентын Өргөдлийн байнгын хорооны дүрэм, чиг үүргийн зохицуулалт, парламентын нээлттэй сонголын зохион байгуулалт, зохицуулалтыг судлан, харьцуулсан дүгнэлт хийсэн.

### **ХУУЛИАР ТОГТООСОН УИХ-ЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭ БА БУСАД ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-12/222

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* П.Амаржаргал

**Захиалагч:** УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей  
**Огноо:** 2012.10.22  
**Сэдвийн агуулга:** Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей гишүүний 8/1872 тоот захиалгын дагуу энэхүү харьцуулсан судалгааг үндсэн хоёр асуудлын хүрээнд гүйцэтгэв. Нэгдүгээрт, Улсын Их Хурлын төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх чиг үүргийн шинжилгээ, Хоёрдугаарт, Парламентын дотоод ажил хариуцсан байнгын хорооны эрх зүйн зохицуулалтын талаархи дэлхийн 6 орны харьцуулсан судалгааг гүйцэтгэв.

#### **ОЛИГАРХИЖСАН УЛС ТӨРИЙН БҮТЦИЙГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-12/223  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Д.Мягмарцэрэн, П.Амаржаргал, Г.Билгээ, Г.Гэрэл, Ч.Онончимэг  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн, *АБГББХ-ийн дарга Ц.Цолмон*  
**Огноо:** 2012.10.24  
**Сэдвийн агуулга:** Улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг салгах, олигархижсан улс төрийн бүтэц үүсэх нөхцөлийг хаах, хязгаарлах асуудлыг онолын түвшинд хэрхэн авч үздэг болон энэ талаарх бусад орны туршлагыг тодруулан гаргахад чиглэгдэнэ. Судалгааны зорилгийг хэрэгжүүлэхийн тулд Олигархижсан улс төрийн бүтэц, улс төр эдийн засгийн ашиг сонирхлын зааг ялгааг эрдэмтэд судлаачид хэрхэн тодорхойлсон талаарх онолын асуудлыг авч үзсэн. Олигархижсан улс төрийн бүтэц үүсэх нөхцлийг хаах, хязгаарлах талаар бусад орнууд ямар бодлого баримталж, хэрхэн зохицуулдаг туршлагыг тодруулсан.

#### **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН БАЙСАН ХҮМҮҮСИЙН ХАНГАМЖ, ХАМГААЛАЛТ, ЭРХ, ҮҮРГИЙН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

**Судалгааны код:** СТ-12/225  
**Судалгааны төрөл:** Дүн шинжилгээ  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, Ц.Товуусүрэн, А.Пагма  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Г.Уянга  
**Огноо:** 2012.11.05  
**Сэдвийн агуулга:** Гадаадын зарим орны, тухайлбал, Америк, Франц, Энэтхэг, Орос, Кыргыз зэрэг орны Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн хангамж, хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалт, Зүүн Тимор Улс, Ангол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн зарим эрх, үүргийн талаарх эрх зүйн зохицуулалтыг судалж, туршлагыг харьцуулан гаргасан.

#### **ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ ДЭХ БАЙНГЫН ХОРООДЫН АЖЛЫН АЛБА**

**Судалгааны код:** СТ-12/227  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, Ц.Товуусүрэн, А.Пагма  
**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар

**Огноо:** 2012.11.12  
**Сэдвийн агуулга:** Уг судалгааг Австрали, Нидерланд, Серби, Аргентин, Швед, Швейцарь, Финланд, Норвег зэрэг улсуудын парламентын тамгын газрын байнгын хороодын ажлын албадаар дамжуулан парламентын байнгын хороодын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлдэг албаны бүтэц, үйл ажиллагааны талаар энэхүү танилцуулгыг бэлтгэв.

#### **“ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ” ЗАРИМ АСУУДАЛ**

**Судалгааны код:** СТ-12/230  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Чулуун  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Ж.Батзандан  
**Огноо:** 2012.12.03  
**Сэдвийн агуулга:** “Төрийн өндөр албан тушаалтны эрхийг хязгаарлах” асуудлын талаар ОХУ, БНХАУ, АНУ, КАНАД улсын эрхзүйн холбогдох зохицуулалтын жишээн дээр харьцуулан судалсан.

#### **ПАРЛАМЕНТЫГ ҮЛ ХҮНДЭТГЭХ ҮЙЛДЭЛ: АГУУЛГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-12/231  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, А.Пагма,  
**Захиалагч:** УИХ-ын Өргөдлийн Байнгын хорооны дарга Р.Бурмаа  
**Огноо:** 2012.12.06  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд хамрагдсан улс орнуудад парламентыг үл хүндэтгэх үйлдлийг хэрхэн тодорхойлдог талаар харьцуулан, парламентыг үл хүндэтгэх үйлдлийг эрх зүйн хувьд хэрхэн зохицуулдаг, ямар шийтгэл ногдуулдаг талаар Австрали, АНУ, Их Британи, Герман, ОХУ-ын жишээн дээр харьцуулан гаргасан.

#### **ПАРЛАМЕНТЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, СОНСГОЛЫН ГЭРЧИЙГ ХАМГААЛАХ, УРАМШУУЛАХ АСУУДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-12/232  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Живгаагүнсэл  
**Захиалагч:** УИХ-ын Өргөдлийн Байнгын хорооны дарга Р.Бурмаа  
**Огноо:** 2012.12.11  
**Сэдвийн агуулга:** Парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг хамгаалах, урамшуулах асуудлын эрх зүйн зохицуулалтыг зарим орны тухайлбал, Австрали, Америк, Канадын жишээн дээр харьцуулан гаргасан.

#### **ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ТАВИХ ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА**

**Судалгааны код:** СТ-12/233  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р. Хатанбаатар, А. Пагма, Д.Живгаагүнсэл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн М.Батчимэг  
**Огноо:** 2012.12.19.

*Сэдвийн агуулга:* Уг харьцуулсан судалгаанд ОХУ-ын Үндсэн хууль, Эрүүгийн хуульд, түүнчлэн Шведийн Вант Улсын Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Эрүүгийн хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд тавих хяналт, хариуцлагын талаар хэрхэн зохицуулсан талаар судалсан.

## **МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ОРЧНЫ ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖИЙН ТАЛААРХ ТОЙМ СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-12/301

*Судалгааны төрөл:* Тойм судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Б.Хатантуул, Б.Мөнхцэцэг, А.Пагма

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Ганхуяг

*Огноо:* 2012.02.09

*Сэдвийн агуулга:* “Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт ба авлигатай тэмцэх орчны эрх зүйн чадамж” сэдвийн хүрээнд Монгол дахь авлигын төлөв байдал, Авилгын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, уг хуулийн авлигатай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах чадамжийн талаар тойм судалгааг гүйцэтгэв.

Судалгааг НҮБ-ын Авилгын эсрэг конвенц, Монгол Улсын Авилгын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг эрх зүйн баримт бичгүүд болон Авлигатай тэмцэх газраас авсан мэдээлэл, тайлан зэргийг авч ашигласан болно. Хээл хахууль авах гэмт хэргийн гадаад орнуудын харьцуулсан судалгааг хийхдээ “Транспэренси Интернэйшнл”-ээс гаргасан Авлигын нөхцөл байдлын индекс -2011 судалгааны дагуу авлига хамгийн их байгаа, хамгийн бага байгаа болон авлига дундаж байгаа орнуудаас сонгон 8 орны эрүүгийн хууль болон Авилгын эсрэг хуулинд хэрхэн зохицуулсныг хүснэгтээр харуулж захиалгыг гүйцэтгэв.

## **УЛСЫН ХУРЛЫН [ТӨРИЙН] СОНГУУЛЬ ба АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГА**

*Судалгааны код:* СТ-12/303

*Судалгааны төрөл:* Тойм судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, Г.Чулуун

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батбаяр

*Огноо:* 2012.04.09

*Сэдвийн агуулга:* Уг тойм судалгааг Монголын нийгмийн удирдлагын уламжлалт хэв шинж (- 1911 хүртэл), ХХ зууны эхэн үеийн монголын нийгмийн улстөрийн байдал, ардчилсан шилжилтийн анхны алхмууд (1911–1924), Анхдугаар үндсэн хуулиар “жинхэнэ ардын сонгуулийн эрх” – ийг хангасан нь (1924), БНМАУ –ын сонгуулийн [хуучин] системийн хөгжлийн эхэн ба дунд үе, Монгол Улсын сонгуулийн [шинэ] тогтолцоо, Ард нийтийн санал асуулга (1945) гэсэн агуулгын хүрээнд судалсан.

## **ТАЙВАН ХУВЬСГАЛЫН БОСГОН ДЭЭРХ МОНГОЛЫН (НИЙГМИЙН) УЛСТӨРИЙН ХӨДӨЛГӨӨН**

*Судалгааны код:* СТ-12/306

*Судалгааны төрөл:* Тойм судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Чулуун

**Захиалагч:** УИХ-ын гишүүн Р.Гончигдорж  
**Огноо:** 2012.10.05  
**Сэдвийн агуулга:** Ардчилсан социалист хөдөлгөөний болон бусад зарим жишээнд түшиглэсэн энэхүү эргэцүүлэлт бяцхан тоймд нийгмийн хөдөлгөөнийг мөн чанар талаас нь сонирхон авч үзэж байгаа байгаа болохоор [хоорондоо шууд ялгамжтай харагдах] “хөдөлгөөн” – үүдийн, хэвшиж хэдийнээ амжсан албан бус олон нэр - нэршилийг юун түрүүнд багцалж авах (цэгцлэх) шаардлагтай арга буюу тулгарч байна. Энд “Нийгмийн (улстөрийн) хөдөлгөөн” -ийг тодорхойлогч зарим шинж чанар, Монголын морин жил (1990) -ийн ардчилсан хувьсгал улстөрийн хөдөлгөөнөөс эхтэй, АСХ [хэлбэрийн талаасаа, чухам] ямар хөдөлгөөн байсан бэ, Улстөрийн хөдөлгөөн (АСХ – I) ба төрийн бус байгууллага (АСХ – II) гэсэн агуулгын хүрээнд эргэцүүлж үзсэн.

### **ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБА БҮХИЙ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-12/402  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** С.Дорждагва, Г.Чулуун, Ө.Мөнхтунгалаг  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн З.Алтай  
**Огноо:** 2012.05.14  
**Сэдвийн агуулга:** Экологийн цагдаагийн алба бүхий гадаадын улс орнуудын эрх зүйн зохицуулалтын онцлог, хэрэгжүүлж буй арга туршлагад холбогдох тойм мэдээллийг Судалгааны Төвд ирүүлсэн захиалагчийн хүсэлтийн дагуу нэгтгэн бэлтгэв. Мэдээлэл лавлагаандаа бид АНУ, ОХУ-ын болон Украин Улсын экологийн цагдаагийн буюу түүнтэй ижил төсөөтэй чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагуудын талаар тусгасан болно.

### **УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН СУДАЛГААНЫ ТӨВИЙН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**

**Судалгааны код:** СТ-12/406  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог, доктор (Ph.D)  
**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
**Огноо:** 2012.09.12  
**Сэдвийн агуулга:** 2002 онд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр (UNDP)-өөс УИХ-ын Тамгын газарт “Ардчилсан парламентын засаглалыг бэхжүүлэх” хамтарсан төсөл хэрэгжүүлж УИХ болон УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргасан. Зөвлөмжид тусгасан гол шүүмж нь “УИХ-аар батлан гаргаж буй хууль, тогтоомж, бодлогын шийдвэрийн онолын болон практик үндэслэлийг сайжруулах, судалгаа тооцооны үндсэн дээр олон нийтийн санаа бодлыг өргөнөөр тусгасан нийгэм, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцсэн “сайн” хуулийг УИХ-аар батлан гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах албыг байгуулах нь зүйтэй” гэсэн санаа байв.

Түүх сөхвөл, анх 1991 онд Улсын Бага хурлын дэргэд Төр нийгэм-судлалын академи байгуулснаас хойш таван удаа өөрчлөгдөж, хамгийн сүүд 2009 оны 1-р сард УИХ-ын Тамгын газрын бүтцэд байгуулсан Судалгааны төвийг байгуулсан. Энэхүү

лавлагаанд Судалгааны төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, чадавхи, гадаад харилцаа, түншлэл, түүний бүтэц зохион байгуулалтын талаар өгүүлсэн ба цаашид тус төвийн чадавхийг сайжруулах тухай саналыг тусгасан.

### **ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-12/407  
*Судалгааны төрөл:* Лавлагаа мэдээлэл  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Ц.Болормаа, Г.Билгээ  
*Захиалагч:* Судалгааны төвийн санаачилгаар  
*Огноо:* 2012.09.12  
*Сэдвийн агуулга:* Тамгийн газрын судалгааны төвөөс 2009 онд дэлхийн зарим улс орны парламентын судалгаа, шинжилгээний үйлчилгээ, 2012 онд дэлхийн 47 орны парламентын ажлын албаны үндсэн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтын талаарх харьцуулсан судалгаа, мэдээллийн ажлыг хийсэн юм. Энэхүү хийгдсэн ажлуудыг харьцуулан парламентын судалгаа, шинжилгээний үйлчилгээ бусад оронд ямар бүтэц зохион байгуулалттайгаар явагдаж буйг хүснэгтээр үзүүлээ.

### **ПАРЛАМЕНТЫН НЭЭЛТТЭЙ СОНСГОЛД ОРОЛЦОГЧДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

*Судалгааны код:* СТ-12/410  
*Судалгааны төрөл:* Лавлагаа мэдээлэл  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Болормаа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн М.Батчимэг  
*Огноо:* 2012.10.22  
*Сэдвийн агуулга:* Нээлттэй сонсголыг зохион байгуулагч буюу сонсгол даргалагч, эсвэл аль нэгэн байнгын хорооны дарга нар хууль болон журмийн дагуу тодорхой хэмжээний үүрэг хүлээдгийг судалгааны үндсэн тайлангийн хэсэгт оруулсан. Дээрх баримт бичгүүдээр парламентын сонсголын төрөл, сонсголд хэрхэн бэлтгэх, гэрчийг хэрхэн сонгох, урих, гэрчийн мэдүүлгийн төрөл хэлбэр, сонсголын ирц, хаалттай сонсгол, гэрчийн эрх, гэрчийг байцаах хугацаа, гэрчийг байцаах журам, нотдлох баримт болон сонсголыг хэвлэл, олон нийтэд мэдээлэх гэх мэт нарийвчилсан харилцааг зохицуулсан байна.

### **ПАРЛАМЕНТЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БҮЛГИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-12/411  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг  
*Огноо:* 2012.10.25  
*Сэдвийн агуулга:* Скандинавын зарим орнууд, пост социалист улсууд болон олон улсын парламентын байгууллагуудын эмэгтэй парламентчдын байгууллага, хороодын талаарх мэдээллийг олж нэгтгэн холбогдох бодлогын хувилбарын талаарх саналаа дэвшүүлэхэд судалгааны зорилго чиглэгдсэн болно.

## **ТАМГЫН ГАЗРЫН ХЭЛТЭС, АЛБА, ТӨВИЙН ЧИГ ҮҮРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

*Судалгааны код:* СТ-12/506

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Ц.Батдорж, Ц.Болормаа, Г.Билгээ

*Захиалагч:* УИХ-ын Тамгын газар

*Огноо:* 2012.03.16

*Сэдвийн агуулга:*

Судалгаанд Тамгын газрын нэгжүүдийн чиг үүрэг, үндсэн үйл ажиллагааны шинжилгээ болон нэгжүүдийн ажлын ерөнхий ачааллыг харьцуулан гаргахыг зорив. Тоон судалгааг Тамгын газрын 2009, 2010 оны ажлын нэгдсэн тайлан, бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөний биелэлтийг үндэслэн гүйцэтгэв.

Тамгын газрын нэгжүүдийн үндсэн чиг үүргийн хүрээнд хийгдэж буй зарим хэлтэс, албадын ажилбаруудыг Ерөнхий нарийн бичгийн даргын 190 тоот захирамжаар баталсан ажилтнуудын “Ажлын байрны тодорхойлолт” бүрээс түүвэрлэн гаргасан ба ЭЗХТХ, БХАА, ЧБХХЗБА, ХМОНХХ зэрэг хэлтэс, албадууд чиг үүргийн хүрээн дэх ажилбаруудын задаргаагаа өөрсдөө гаргаж ирүүлсэнийг суурь мэдээлэл болгон ашигласан болно. Хэлтэс, албадын гаргаж ирүүлсэн мэдээллүүд харилцан адилгүй, зарим нь хэт товч, зарим хэт задлан гаргасан байсан тул чиг үүргийн задаргааг бодлогын, зөвлөх, техник зохион байгуулалтын гэж ангилан нарийвчилж гаргахад хүндрэлтэй байсан болно. Иймд бодлогын чиг үүргийг зөвхөн хууль тогтоох үйл ажиллагаанд шууд оролцдог нэгжүүдийн хувьд тодорхойлсон болно.

Судалгааны дүнд дээрхи асуудлуудыг задлан шинжилж, хэлтэс, албад, төвийн ерөнхий ачаалал, чиг үүргийн давхардал, хийдэл байгаа эсэхэд анализ хийж нэгтгэн дүгнэсэн болно.

---

## **2013 ОН**

### **ЛОББИ БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-13/201

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* П.Амаржаргал, Б.Хатантуул, Б.Цолмонбаяр

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Номтойбаяр

*Огноо:* 2013.01.21

*Сэдвийн агуулга:*

Судалгаанд АНУ, Англи, Герман, Итали, Канад, Франц, Япон зэрэг нийт 7 улсын хувьд лобби болон сонирхлын бүлгүүдийн хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг харьцуулан, онцлог байдлыг авч үзсэн.

### **ПАРЛАМЕНТЫН ТАНХИМД ГИШҮҮДИЙГ СУУЛГАХ ЭРЭМБЭ ДАРААЛЛЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-13/203

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Б.Хатантуул



**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын ЕНБД Б.Болдбаатар  
**Огноо:** 2013.01.07  
**Сэдвийн агуулга:** Уг асуудлын хүрээнд Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг, ОХУ, Солонгос, Канад, Сингапур, Финланд, Испани улсуудыг судалсан болно. Судалгаанаас үзэхэд:

- Австрали, Шинэ Зеланд, Солонгос, Энэтхэг улсын хувьд бол Спикер суудал хуваарилах болон дарааллын асуудлыг шийдвэрлэдэг байна.
- ОХУ хувьд түр ажлын хэсэг байгуулан, гишүүдийг Танхимд суух суудлын дарааллыг тогтоодог байна.
- Норвеги улсын хувьд бол сонгогдсон тойргийнхоо нэрийн цагаан толгойн дарааллаар Танхимд суудаг.
- Канад, Сингапур, Финланд, Испани улсуудын хувьд Парламентын дэгийн тухай хууль болон Парламентын дүрэмдээ нарийвчлан тусгаагүй.

### **ЦЭРГИЙН АЛБА ХААХ ХУГАЦААНЫ ТАЛААРХИ ГАДААДЫН УЛС ОРНЫ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-13/207  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, Г.Чулуун  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат  
**Огноо:** 2013.01.29  
**Сэдвийн агуулга:** Цэргийн алба хаах хугацааны талаарх гадаадын улс орны эрхзүйн зохицуулалт (ОХУ, АНУ бусад улс орны жишээн дээр хийсэн лавлагаа, харьцуулалт)

### **“ЧИНГИС ХААН” НЭР, “ЧИНГИС ХААНЫ ХӨРӨГ”-ИЙГ ГАДААД УЛСАД ХЭРЭГЛЭХ, АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ”**

**Судалгааны код:** СТ-13/210  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** П.Амаржаргал  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Ганбат  
**Огноо:** 2013.02.25  
**Сэдвийн агуулга:** Уг судалгаанд хамааруулан Монгол Улсын нэгдэн орсон “Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр” (Madrid Agreement Concerning the International Registration of Marks), “Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол” (Protocol Relating to the Madrid Agreement Concerning the International Registration of Marks.), “Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц” (Convention Establishing the World Intellectual Property Organization), “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц” (Paris Convention for the Protection of Industrial Property) зэрэг олон улсын гэрээ, конвенц, протокол, хэлэлцээрийг авч үзсэн болно.

## **СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-13/212  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Товуусүрэн, Б.Хатантуул  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Оюун, С.Дэмбэрэл  
**Огноо:** 2013.02.28  
**Сэдвийн агуулга:** Энэхүү судалгаагаар Сонгуулийн хуулийн сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоо бүхий 7,8 дугаар бүлгийн заалтуудыг улам боловсронгуй болгоход чиглэгдсэн гадаадын улс орнуудын энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад оршив. Анли, Канад, Японы Сонгуулийн хуулийн сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилттэй холбоотой зохицуулалтуудыг судлав.

## **БУСАД ОРНУУДЫН ПАРЛАМЕНТ ДАХЬ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЖУРАМ**

**Судалгааны код:** СТ-13/220  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** П.Амаржаргал  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн, ӨБХ-ны дарга Р.Бурмаа  
**Огноо:** 2013.02.28  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Австрали, Бүгд Найрамдах Латви Улсын парламентын Өргөдлийн байнгын хорооны дүрэм, журам болон өргөдөл гомдол хүлээн авах журам, түүнд тавигдах шаардлага, өргөдлийн загвар, өргөдөлд хариу өгөх зэрэг иргэдээс нийтийн эрх зүйн субъектэд өргөдөл гаргах эрх, журмыг харьцуулан гаргахыг зорьсон болно.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ФРАНЧАЙЗИЙН ХУУЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ**

**Судалгааны код:** СТ-13/223  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог (Ph.D), Д.Байгалмаа, Г.Гэрэл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Ж.Батзандан  
**Огноо:** 2013.02.28  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Франчайзийн системийг өргөн ашигладаг Хятад, Бразил, Итали зэрэг орнуудыг сонгон авч, тэдгээрийн франчайзийн хууль, түүнтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг ашиглалаа. Эдгээр орнуудын франчайзийн хууль нь франчайзийн харилцааг бүхэлд нь зохицуулах биш, хэсэгчилсэн байдлаар зохицуулж байгаа нь магадгүй, тус бизнес нь өөрөө олон салбарыг хамарч олон чиглэлд хийгддэг, тухайн бизнесээсээ шалтгаалан франчайз шилжүүлэгч /franchiser/-ээс тавигдах нөхцөл нь өөр өөр байдаг гэх мэтийн хүчин зүйлүүдээс хамаарч франчайзийн харилцааг нэгдсэн байдлаар стандартчилах, хэм хэмжээ тогтооход хүндрэлтэй байдаг болов уу гэсэн таамаглал дэвшүүлж байна. Үүнээс улбаалан эдгээр орнуудын эрх зүйн актуудын нийтлэг зарчим нь франчайз хүлээн авагч /franchisee/-ийн эрх ашгийг хамгаалах, франчайз шилжүүлэгчийн үүргийг илүү тусгаж өгснөөрөө онцлогтой бөгөөд эрх зүйн орчны зохицуулалтыг хийхдээ франчайзийн системийн голлох баримт бичиг болох франчайзийн гэрээ /franchising contract/,

франчайзийн системийн мэдэгдэл /franchise offer circular/-ийг илүү тодотгон тусгадаг юм байна .

### **ОЛОН УЛСЫН БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-13/232  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Батцогт  
*Огноо:* 2013.09.25.  
*Сэдвийн агуулга:* Олон улсын ба гадаадын зарим орны үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын эрх зүйн зохицуулалт, чиг үүрэг, эрх хэмжээ, бүтэц зохин байгуулалтын талаар болон энэ асуудлаар дэлхийн болон бүс нутгийн олон улсын байгууллагын зөвлөмж, тайлан, судалгааны материалын жагсаалтыг бэлтгэв.

### **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛД ХАМААРАЛ БҮХИЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДААГ ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ “СУБЪЕКТ”**

*Судалгааны код:* СТ-13/236  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Чулуун  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн М.Батчимэг  
*Огноо:* 2013.10.14.  
*Сэдвийн агуулга:* Монголын нийгмийн хотжиж процесс “дур зоргоор, нялх, туршлагагүй”, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратегийн зохицуулалт сул байгаагийн улмаас улсын нийслэлийн замын нэвтрүүлэх чадамж буурч осол зөрчил ихэсч байна. Замын түгжрэл нь замын нэвтрүүлэх чадамжийн дам илэрхийлэл байдаг. Нэвтрүүлэх чадамжийн үзүүлэлт нь эргээд замын хөдөлгөөний аюулгүй байдлын нэг ёсны итгэлцүүр болдог.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудалд хамаарал бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нэгдмэл уялдааг гадаадын улс оронд хэрхэн хангадаг; талаарх сэдэвчилсэн товч мэдээлэл, ОХУ, БНХАУ болон гадаадын бусад орны эрх зүйн зохицуулалтын жишээнд түшиглэсэн лавлагаа юм. (Нийт 7 хууд.)

Лавлагаанд, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хуулийн дагуу үүрэг хүлээсэн төрийн болон бусад байгууллагуудын ажлын нэгдмэл уялдааг гадаадын улс орнуудад нутгийн захиргааны байгууллага хангадаг –ийг жишээ баримттай дурдаад саналын чанартай доорх санааг тусгажээ. Үүнд:

- Замын хүртээмж буурахад нөлөөлдөг хүчин зүйлсийн хүрээг зөв зөв тодорхойлох;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дотор нь стратеги ба тактикийн чиг баримжаагаар зааглаж, алсыг харсан бүтээн байгуулалтын чанартай ажилбаруудыг зам дээр явагддаг өдөр тутмын урсгал зохицуулалтаас салгаж авч үзэх;

- Яам хоорондын ажил асуудлыг хамтарсан тушаалаар зохицуулчихаж болдог бол олон газрын хамааралт үйл ажиллагааг талуудын эрхийн тэнцвэр дээр нэгтгэн зохицуулах бололцоо харьцангуй бага, завсарт нь ажил эзэнгүйдэн орхигддог тул, замын хөдөлгөөний стратеги зохицуулалтыг дагнан хариуцдаг, удирдан зангидах, уялдуулан зохицуулах үүрэг бүхий захиргааны бүтэц бий болгох;

Олон салбар дундын онцлог чанараасаа болоод хууль тогтоомжоор тэр бүр тодорхой сайн эзэнжиж өгдөггүй, сугараад үлдчихдэг, хаягдчихдаг, сайн саар дагавар нь нийгэмд шууд мэдрэгддэг “замын хөдөлгөөний стратеги зохицуулалт” –ын бүлэг ажил “багц хуульгүй, барьж хөөцөлдөх эзэн-байгууллагагүй” явж ирсэн гэсэн санааг ч мэдээлэлд мөн тусгажээ.

### **ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ПРАКТИКТ “ГЕНИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ” АШИГЛАЖ ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

*Судалгааны код:* СТ-13/241

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ш.Түвдэндорж

*Огноо:* 2013.12.10

*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь Шүүхийн шинжилгээний практикт генетик мэдээллийн сан бүрдүүлэн ашиглаж буй гадаадын улс орнуудын туршлага, хууль эрх зүйн орчныг судалж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд анхаарвал зохих асуудлуудыг тодруулахад чиглэгдсэн.

### **БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН АЖЛЫН АЛБАДЫН ТУХАЙ**

*Судалгааны код:* СТ-13/401

*Судалгааны төрөл:* Лавлагаа, мэдээлэл

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Ц.Товуусүрэн, А.Пагма

*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын ЕНБД Б.Болдбаатар

*Огноо:* 2013.01.07

*Сэдвийн агуулга:* БНСУ-ын Үндэсний Ассамблейн Ажлын албадын үйл ажиллагааны талаар лавлагааг бэлтгэхдээ Үндэсний Ассамблейн Тамгын газар, Номын сан, Төсвийн шинжилгээний алба, Судалгааны албадын бүтэц, үйл ажиллагаа, ажлын онцлог, туршлагыг тусган, бүтэц, үйл ажиллагааны бүдүүвч зэргийг харуулан уг мэдээллийг бэлтгэсэн.

### **ПАРЛАМЕНТ ДАХЬ НАМЫН БҮЛГҮҮДИЙГ ЧУУЛГАНЫ ИРЦ БҮРДҮҮЛЭЭГҮЙ ШАЛТГААНААР ТАРААХ ҮНДЭСЛЭЛ БИЙ ЭСЭХ ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-13/402

*Судалгааны төрөл:* Лавлагаа, мэдээлэл

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Б.Хатантуул

*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей

*Огноо:* 2013.01.30

*Сэдвийн агуулга:*

Уг асуудлын хүрээнд Казахстан, Узбекистан, Молдова, Киргиз, Армен, Шинэ Зеланд, Испани, Аргентин, ОХУ, Франц, Серби улсуудыг судалсан болно.

- Казахстан, Узбекистан, Молдова, Киргиз, Армен, Шинэ Зеланд, Испани улсуудын хувьд бүлгийн гишүүдийн тоо нь бүлгийг бүртгэх тоонд хүрэхгүй болсон тохиолдолд бүлэг үйл ажиллагааг зогсоодог.
- Узбекистан, Киргиз улсын хувьд мөн түүнчлэн өөрийн санаачлагаар эсвэл хууль тогтоох танхимын бүрэн эрхийн хугацаа дууссан үед бүлгийн үйл ажиллагаа зогсдог.
- Аргентин Улсын Депутатуудын Танхимын дүрэм, Үндэсний Конгрессын Акт, ОХУ-н Төрийн Думын Регламент, Францын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг, Сербийн Үндэсний ассамблейн дэг болон Үндэсний ассамблейн хуульд намын бүлгийг тараах асуудлаар нарийвчлан тусгаагүй байна.

### **ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГАД ХОЛБОГДОХ ЗАРИМ ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-13/403

*Судалгааны төрөл:* Лавлагаа, мэдээлэл

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Чулуун

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат

*Огноо:* 2013.02.04

*Сэдвийн агуулга:* Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн тухайлсан зарим заалт, тэдгээрийн [хүлээгдэж байгаа] өөрчлөлтийн талаар лавлагаа тодруулга хийв. Үүнд:

- 1) Монгол Улсад цэргийн алба хаах хугацааг өөрчилж байсан шалтгаан нөхцөл;
- 2) Цэргийн алба хаах хугацааг 24 сар болгон өөрчилж хуульчилсан тохиолдолд, уг шийдлээс, улсын нийгэм эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөөлөл
- 3) Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 5-р зүйлийн 5.2.7-д дурдсан “цэргийн албан хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах”-д [өнөөгийн] 12 сарын хугацаа хүрэлцээтэй эсэх;
- 4) Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь заалт -ыг хүчингүй [болсоноос] үүсэх үр нөлөө;
- 5) Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын тоо; /сүүлийн 5 жилийн байдлаар/
- 6) Гадаадын улс орнууд дахь цэргийн алба хаах хугацааны талаархи зохицуулалт, харьцуулалт;

### **НИЙТИЙН АЛБАНД АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР**

*Судалгааны код:* СТ-13/404

*Судалгааны төрөл:* Лавлагаа, мэдээлэл

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ж.Батзандан

**Огноо:** 2013.02.04  
**Сэдвийн агуулга:** НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Азийн хөгжлийн банк, түүнчлэн АНУ-ын “Олон улсын хөгжлийн агентлаг”, “Муж улсуудын шүүхийн үндэсний төв” зэрэг судалгааны байгууллагаас санхүүжүүлж монголын иргэний нийгмийн байгууллагуудын өргөн оролцоотойгоор гүйцэтгэсэн судалгаанууд Монгол дахь авлигын төлөв байдал, авлигын тухай иргэдийн төсөөлөл, хандлагыг бодит байдлаар тодорхойлоход ач холбогдол бүхий хангалттай мэдээлэл агуулсан байна.

### **МОНГОЛЫН НЭРТЭЙ УЛС ТӨРЧ ЭМЭГТЭЙЧҮҮД**

**Судалгааны код:** СТ-13/407  
**Судалгааны төрөл:** Лавлагаа, мэдээлэл  
**Гүйцэтгэсэн судлаач:** Т.Мягмаржав  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Оюунхорол  
**Огноо:** 2013.02.04  
**Сэдвийн агуулга:** Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо урьд байгаагүйгээр идэвхжсэний шинж нь хуучин шиг төрийн бодлогоор төлөөлөл маягаар эмэгтэйчүүд байх бус эрчүүдтэй эн зэрэгцэн өрсөлдөж өөрсдийн чадлаараа байр сууриа эзэлж буй явдал юм. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс туршлага, мэдлэгийн хувьд ялгаатай байдаг ч бид нэгэнт жендэрийн хуваарилалт бүхий нийгэмд амьдарч байгаа нь нийгмийн нийтлэг эрх ашгийг хангахуйц шийдвэр гаргах боломжоор хангагдсан нийгмийг бүрдүүлэхэд оршино. Хариуцлагатай өндөр түвшний албан тушаалыг хаших чадварын хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь адилхан гэдгийг хүмүүст ойлгуулснаар илүү сайн хүнийг сонгох магадлал улам бүр ихэсдэг. Монгол Улсад байнгын ажиллагаатай парламенттай болсон хугацаанд УИХ-ын гишүүнээр сонгогдсон эмэгтэй гишүүдийг парламентад эзэлж ирсэн хувийг авч үзвэл: 1992-1996 онд 3,9 хувь, 1996-2000 онд 9,2 хувь, 2000-2004 онд 11,8 хувь, 2004-2008 онд 6,6 хувь байсан бол 2008 оны сонгуулиар байгуулагдсан парламентад эмэгтэй гишүүдийн эзлэх хувь эргээд 3,9 хувьтай болчихоод байсан. 2012 оны сонгуулиар байгуулагдсан парламентад “Улсын Их Хурлын Сонгуулийн тухай” хуульд эмэгтэйчүүдийн нэр дэвших боломжийг 20 хувийн квотоор тогтоож өгсөнөөр парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувь 14,4 хувь болсон байна.

### **МОНГОЛ УЛС ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН АКТУУДЫН ХЭРЭГЖИЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭЖ БУЙ ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-13/411  
**Судалгааны төрөл:** Лавлагаа, мэдээлэл  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ө.Мөнхтунгалаг  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Эрдэнэ  
**Огноо:** 2013.06.25  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг олон улсын байгууллагуудын үнэлгээ болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнд үндэслэн тодорхойлж, авлигатай тэмцэх эрх зүйн актуудын хэрэгжилтийн талаарх статистик мэдээлэл, авлигын олон улсын нөхцөл байдал, бусад орны авлигатай тэмцэх эрх зүйн

орчны хүрээнд холбогдох олон улсын байгууллага, мэргэжлийн байгууллага болон Тамгын газрын судлаачдын өмнө нь хийсэн судалгааны мэдээллийг тойм хэлбэрээр бэлтгэсэн болно.

## **ГАДААДЫН УЛС ОРНЫ “ЖОЛООЧ БЭЛТГЭХ АРГА ТОГТОЛЦОО, ЖОЛООНЫ ШАЛГАЛТ АВАХ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЭРХ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА” –ЫН ТАЛААРХ ЗАРИМ ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-13/418

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Чулуун

*Захиалагч:* УИХ-ын гишүүн М.Батчимэг

*Огноо:* 2013.09.30

*Сэдвийн агуулга:* Лавлагаанд, [ОХУ, БНХАУ, ХБНГУ, АНУ .. зэрэг] гадаадын улс орнуудад “тээврийн хэрэгслэлийн жолоочийн шалгалт авах, жолооны үнэмлэх олгох ажлыг [тэндэхийн] ямар байгууллага эрхлэн хариуцдаг ..” –ийг энд жишээлэн тодруулжээ.

Жолоодох эрхийн үнэмлэхийг авах олгох асуудал заавал “шалгалт өгөх”, шалгжжр давах зарчмын үндсэн дээр шийдэгддэг нь дэлхийн аль ч улс оронд нийтлэг; гэж үзэж болохоор байна. Харин, жолооны шалгалтад хүнийг бэлдэх (бэлтгүүлэх), шалгалтыг хаанаас яаж авах нь улс орон бүрт тэр бүр харилцан адилгүй юм. Лавлагааны агуулгад зарим санаа санал туссан. Үүнд:

- Монголд “жолоочийн пермит эрх” үгүй тул, манай Автотээрийн тухай хуулийн агуулга дахь “мэргэшсэн жолооч” ухагдахууныг дахин тодорхойлох шаардлагатай;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн засаг төрийн бодлогын тодорхойлогч нэг чухал хүчин зүйл нь “жолооч бэлтгэх үйл явцад [дээрээс] тавих хатуу чанд хяналт мөн” гэсэн үзэл хандлагыг өөрчлөх;
- Олон улс орон иргэндээ “жолооны эрх” –ийг нь өгөхгүйн төлөө биш, чухамхүү өгөхийн төлөө .. асуудалд уян хатан, ө. х. зохион байгуулалтын хариуцлагатай бөгөөд шударга [аль болох авилгагүй, аядуу зөөлөн, захиргаадалтын биш] арга тактик баримталдаг; .. г. м.

## **ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-13/422

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Оргилмаа

*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ӨБХ-ны дарга Р.Бурмаа

*Огноо:* 2013.10.15

*Сэдвийн агуулга:* Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хууль эрх зүйн орчинг сайжруулахад Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Канад улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Оросын Холбооны Улс зэрэг бусад орны туршлагын талаар мэдээлэл лавлагааг хийж гүйцэтгэв.

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ**

*Судалгааны код:* СТ-13/501

*Судалгааны төрөл:* Дүн шинжилгээ

*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа, Д.Байгалмаа, Г.Гэрэл  
Ч.Онончимэг

*Захиалагч:* УИХ-ын гишүүн М.Батчимэг

*Огноо:* 2013.01.17

*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь дүн шинжилгээний болон судалгааны хэсгүүдээс бүрдэнэ. Судалгаанд эдийн засгийн байдлын тухай ойлголт түүний судлагдсан байдал, эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд, түүний үнэлгээний индикаторууд, Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын өнөөгийн байдал, эдийн засгийн аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлүүдийг судалсан болно.

Мөн түүнчлэн УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”- д тусгагдсан Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох зорилт, Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого, төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлын эрсдэл, эрчим хүч, эрдэс баялгын салбарын бодлого, гадаад худалдаа, интеграцийн бодлогын хэрэгжилт эрсдэлийн өнөөгийн байдлыг статистик мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн.